

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-34

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/	5-8
2.Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох	8-20
3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох	20-34

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 02-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах, С.Цэнгүүн;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар;
Тасалсан: Ч.Номин.

1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хэлэлцэх асуудлын 3 дугаарт орсон “Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 1 дүгээрт хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хэлэлцэх асуудлын 1 дүгээрт орсон Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох асуудлыг 3 дугаарт хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир үг хэлэв.

Ж.Золжаргал: “Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, Инновацын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхбат, Салбарын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Эрүүл мэндийн яамны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтсийн дарга Э.Мягмар-Өлзий, мөн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхтуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Б.Нарантуяа, мөн төвийн Цахим хөгжлийн хэлтсийн дарга Б.Үзмээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Ч.Ундром, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрүүл мэндийн яамны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтсийн дарга Э.Мягмар-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, Инновацын бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Мөнхбат, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо ТББ-ын төлөөлөл Ч.Чимиддорж, Монголын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, шийдэл нийлүүлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл У.Эрдэнэбямба, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл А.Баттамир, Хэрэглэгчийн систем нийлүүлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл Ж.Баянмөнх, Цахим бүтээгдэхүүн хөгжүүлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл Б.Батжаргал, Бизнес шинжээчид, төслийн удирдагчдын холбоо ТББ-ын төлөөлөл Ч.Агиймаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, мөн албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү болон Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл А.Баттамир, Бизнес шинжээчид, төслийн удирдагчдын холбоо ТББ-ын төлөөлөл Ч.Агиймаа нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Б.Бат-Өлзий, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын Ц.Мөнхбат, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү болон Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл А.Баттамир, Бизнес шинжээчид, төслийн удирдагчдын холбоо ТББ-ын төлөөлөл Ч.Агиймаа нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 18 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
16 цаг 35 минут.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Эрхэм гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Анар, Улсын Их Хурлын гишүүн Батшугар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан, Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Золжаргал гэсэн, Цэнгүүн гишүүн байхгүй байгаа юм байна. Цэнгүүн гишүүн байхгүй юм байна шүү. Золжаргал гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ирц 54,5 хувьтай байна. Ирц хүрсэн тул Байнгын хорооны хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилт болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох. 2 дугаарт нь Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаар Эрүүл мэндийн сайдын мэдээлэл сонсох. 3 дугаарт нь Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байгаа.

Тайлбар хэлэхэд нэгдүгээрх нь Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль батлагдаад нэлээн хугацаа өнгөрсөн боловч хэрэгжилтгүй байгаа журмууд нь удаад байгаа. Үүнийг яаравчлах, ямар шалтгаан байна вэ гэдгийг яамны зүгээс. Тэгээд нөгөө нийтийн мэдээллийг big data болгож ашиглах бас удаад байна. Энэ талаар ярилцана. Гуравдугаарх Тогтоолын төсөлд өөрчлөлт оруулах гэдэг нь болохоор хилийн чанад дахь Монголчуудын цахим оролцоог нэмэгдүүлэх, цахимаар сонгуульд оролцох боломжийг судлах ажлын хэсэг байгаа энэ талаар. Тэгэхээр хугацааны хувьд хамгийн хурдан байхыг нь хамгийн түрүүнд хэлэлцээд, дарааллыг энэ өөрчилье гэсэн ийм санал миний хувьд байна. Хэлэлцэх асуудал дээр гишүүд, бусад гишүүд санал байна уу? Алга. Тэгвэл хэлэлцэх асуудал дээр ийм санал байна.

Хэлэлцэх асуудал 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилт болон Мэдээллийн технологи үйлдвэрлэл дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох гэдэг асуудлыг 3 дугаарт оруулъя гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. Санал санал дэмжигдлээ. Хэлэлцэх асуудлын 3-д байсан Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт оруулах талаар санал хураая. Санал хураалт. Санал дэмжигдлээ. Баярлалаа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай/

Ингээд хэлэлцэх асуудал 1. Байнгын хорооны тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж эхэлнэ, хэлэлцэнэ. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац цахим, бодлогын байнгын хорооноос тогтоох нь. 1. Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны ажлын хэсэг байгуулах тухай 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Б.Уянга нарыг нэмсүгэй. Ийм томъёололтой байна.

Тэгэхээр энэ ажлын хэсэг маань Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир ахлаад хилийн чанад дахь Монголчуудын ИМонголиа цахим төрийн цахим үйлчилгээг сайжруулах, тэгээд цахимаар сонгуульд оролцох боломжийг судалж санал, дүгнэлт боловсруулах гэсэн ийм агуулгатай даалгавартай явж байгаа. Тэгээд үүнд Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл болон Уянга ажлын хэсэгт орох хүсэлтээ бичгээр ирүүлсэн. Тэгээд энэ саналынх нь дагуу тогтоолын төслийг бэлдсэн болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү? Асуулт асуух, үг хэлэх гишүүн байхгүй байна. Бум-Очир гишүүн тийм мэдээлэл хэлэх үү? Баярлалаа. Бум-Очир гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Д.Бум-Очир: Баярлалаа. Юуны өмнө бас энэ ажлын хэсэгт орж ирж байгаа гишүүддээ талархал илэрхийлье. Бас энэ их чухал асуудал. Тэгээд энд ач холбогдол өгч ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтээ илэрхийлсэнд талархаж байгаагаа илэрхийлье. Та бүхэндээ нэг товчхон их цаг авахгүйгээр богинохон мэдээлэл хүргэхийг хүсэж байна. Тэр юу вэ гэхээр хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл гэж байгууллага байдаг. Энэ хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл Их Хуралд нэг хүсэлт явуулсан. Тэр хүсэлтээ явуулахдаа надад хаяглаж явуулсан байгаад байгаа. Энэ нөгөө би бас өмнө нь Ерөнхийлөгчийн соёл, шашны бодлогын зөвлөхөөр ажиллаж байх үед Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран ажиллаж байсан тэр шалтгаанаар бас энэ ажилд намайг жаахан ойрхон байх болов уу гэдэг үүднээс надад хаяглаад нэг хүсэлт ирүүлсэн.

Тэр нь юу вэ гэхээр хилийн чанад дахь Монголчуудын эрх ашгийг хамгаалах Их Хурлын лобби буюу дэмжих бүлгийг байгуулж өгөх ийм хүсэлт ирүүлсэн. Энэ оны өмнөх үйл явдал. Энэ хүсэлтийг нь хүлээж аваад сонирхож ажиллах гишүүдэд мэдэгдсэний үндсэн дээр одоогоор 19 гишүүн гарын үсэг зураад, лобби бүлэг дэмжих бүлэг байгуулагдсан. Ингээд дэмжих бүлгийн анхны хуралдааныг хийсэн байгаа. Энэ хуралдааны нэг талд нэг ийм хуралдаан болсон. Тэгээд энэ Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс бас энэ ажлаа лобби бүлгээ намайг ахлах ийм санал ирүүлсэн. Энийг бас яг лобби бүлгийн гишүүддээ танилцуулаад, гишүүдийн дэмжсэнээр миний бие одоогоор энэ дэмжих бүлгийг ахлан ажиллаж байгаа юм.

Энэ хүрээнд нэлээд ажлууд бид төлөвлөөд эхнээс нь хийж эхэлж байгаа. Яг энэ ажлыг мөн энэ цахим бодлогын Инновац, цахим бодлогын байнгын хороо мөн дэмжин ажиллаж байгаад би бас онцгойлон талархал илэрхийлмээр байна. 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн Байнгын хорооны хуралдаанаар хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээ ИМонголиа системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний дата төв болон ИМонгол академиас мэдээлэл хийсэн байгаа. Энэ мэдээллийн үндсэн дээр бид нэг ажлын хэсэг гаргах нь зүйтэй юм байна гэдэг ийм шийдэлд хүрсэн. Энэ ажлын хэсэг нь хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн

үйлчилгээний нэгдсэн ИМонгол системийг хүртээмжтэй болгох, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал, дүгнэлт танилцуулах шүү. Тэгэхээр ажлын хэсгийн үүрэг судлаад санал, дүгнэлт боловсруулах хэмжээнд чиглэл бүхий ажлын хэсэг гарсан. Мөн энэ ажлын хэсгийг надаар ахлуулаад явж байна. Энэ ажлын хэсэгт маань сая гишүүд нэмэгдэж орж байгаа тухай танилцууллаа. Яг энэ хүрээнд ажлын хэсэг маань одоохондоо эцэслэн байгуулагдаж хурлаа.../минут дуусав/

Ж.Золжаргал: Микрофон нэмж өгнө үү.

Д.Бум-Очир: Баярлалаа. Тэгэхээр энэ хүрээнд бид ажлын хэсгийнхээ удирдамж болоод ажлын төлөвлөгөөг боловсруулах шатад явж байна. Энэ долоо хоногт ажлын хэсгээ хуралдуулъя гэсэн арай бичиг цаас нь бэлэн болоогүй байгаа учраас ирэх долоо хоногт хуралдуулахаар, нэгд гишүүд маань бас эцэслэгдэж нэр нь тодроогүй байгаа учраас ажлын хэсгээ ирэх долоо хоногт хуралдуулъя гэж бодож байгаа. Ирэх долоо хоногийнхоо хуралдаан дээр бид ажлын хэсгийнхээ удирдамж болоод ажлын төлөвлөгөөг танилцуулж гишүүдээсээ санал авах ийм бодолтойгоор төлөвлөж байна.

Түүнчлэн яг энэ хүрээнд бид мөн энэ ажлыг дэмжин ажиллах хуучин дэд ажлын хэсэг гэж нэрлэдэг байсан юм байна. Одоо бол дэд ажлын хэсэг гэдэг нэр томъёог хараахан хэрэглэхгүй байгаа юм байна. Тэгэхдээ энэ ажлыг дэмжин ажиллах бүрэлдэхүүнийг бид төвлөрүүлж зохих байгууллагууд руу хүсэлт илгээсэн байгаа. Жишээ нь Гадаад харилцааны яам, миний баланк дээр явж байгаа. Гадаад харилцааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сонгуулийн ерөнхий хороо, Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, ИМонгол академи, Үндэсний дата төв, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэсэн газрууд руу ийм ажлын хэсэг байгуулагдах гэж байна. Энэ ажлын хэсгийн ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ чиглэлээр ажиллаж байгаа хүмүүсээ дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулан хамтран ажиллаж, хүнээ өгнө үү гэсэн ийм албан бичиг одоогоор явуулчихсан. Бүрэлдэхүүн байгуулах гээд байж байна. Нэгэнтээ байгуулагдсаны дараа энэ бүрэлдэхүүндээ чухам ямар, ямар асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар дараа дараагийн ажлууд хийгдээд явах ийм төлөвлөгөөтэй байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Мэдээлэл өгсөн Бум-Очир гишүүнд баярлалаа. Тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ. Хилийн чанад дахь Монголчуудын цахим оролцоог нэмэгдүүлэх, цахимаар сонгуульд оролцох боломжийг судалж санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн Уянга нар нэмэгдэж орлоо.

Хилийн чанад дахь Монголчуудын хамгийн гол үндсэн эрхийн нэг нь улс төрийнхөө эрхийг эдэлж сонгуульд оролцох явдал. Тэгээд сая энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Чех улсад, Польш улсад хийсэн айлчлал, Улсын Их Хурлын даргын Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад хийсэн айлчлалын үеэр Монгол иргэдтэй уулзаж ярилцахад энэ дээр маш их ач холбогдол өгч байгаа. Тэгээд энэ утгаараа энэ ажлын хэсэг маань богино хугацаанд, үр дүнтэй ажиллана байх гэж найдаж байна. Төрийн байгууллагууд цахим оролцоог нэмэгдүүлэх, цахимаар сонгууль авах боломж өөр ямар хувилбарууд байх вэ гэдэг дээр нэлээн хэмжээний судалгаа хийгээд, тодорхой ажлууд бэлтгэгдсэн байгаа. Тэгэхээр богино хугацаанд

дүгнэлт гаргах байх гэж найдаж байгаа. Тэгээд Байнгын хорооны зүгээс дэмжиж ажиллана.

16.45 цаг

Хоёр.Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаарх Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэх асуудал 2. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаар Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсох. Ажлын хэсгийг оруулчихъя. Ажлын хэсгийг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан, ЭМЯ-ны Стратеги төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг, ЭМЯ-ны Мэдээлэл, цахим хөгжлийн хэлтсийн дарга Мягмар-Өлзий, ЭМЯ-ны Хөгжлийн төвийн Цахим хэлтсийн дарга Үзмээ, ЭМЯ-ны Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Энхтуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Нарантуяа, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Алтан-Од, Цахим хөгжлийн бодлогын газрын дарга Бат-Өлзий, Инновацийн бодлого, зохицуулалтын газрын дарга Мөнхбат, Салбарын бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч Батзаяат, Үндэсний дата төвийн дарга Баттулга, ИМонгол Академийн захирал Мягмарнаран орсон байна. Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан танилцуулга хийнэ. Баярлалаа.

Т.Мөнхсайхан: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүд ээ, та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Алсын хараа 2050-д эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдсэн байх зорилтыг дэвшүүлэн тавьсан. Зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбараас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх, нотолгоонд суурилсан өгөгдлийг бодлого боловсруулахад ашиглах, эрүүл мэндийн их өгөгдөл бий болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэнд цахимаар хүргэн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүлээгдэл чирэгдлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар товч танилцуулъя.

Эрүүл мэндийн салбарт бүртгэлтэй 4700 гаруй эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт 60 мянга гаруй албан хаагчид ажиллаж байна. Үүнээс аймаг, дүүргийн эмнэлгийн байгууллагуудад нийт 272 эрүүл мэндийн мэдээлэл технологийн ажилтан ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2020 оноос өмнө цахим технологийг зөвхөн тусламж үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, эрүүл мэндийн статистик үзүүлэлт тооцох зорилгоор ашиглаж байсан бол 2021 оноос хойш эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал үр ашгийг тооцох, иргэдэд цахимаар зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, эмийн жорыг цахимаар хянаж олгох, алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байгаа иргэдэд мобайл тусламж үйлчилгээ үзүүлэх, алсын зайнаас зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулахад теле... ашиглах, хиймэл оюун ухаанд суурилсан тоног төхөөрөмж нэвтрүүлэх зэргээр өргөнөөр ашиглаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 206 дугаар захирамжаар эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг салбарын дундын оролцоотой байгуулагдан, эрүүл мэндийн салбарын цахимжилтын чиглэлээрх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэдээллийг иргэнд төрийн үйлчилгээний нэгдсэн платформ

ИМонгол системээр хүргэх, эрүүл мэндийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоолоор эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам, эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага, үнэлгээ хийх мэдээлэл журмыг тус тус батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Өнөөдрийн байдлаар ИМонгол платформоор дамжуулан жирэмсний хяналт, эх хүүхдийн хяналт, эмийн жор, шинжилгээний хариу, хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ, дүрс оношилгооны дүгнэлт гэх зэрэг нийт 25 үйлчилгээг иргэнд хүргэж байна.

Бид одоогоор салбарын цахимжилтын хүрээнд салбар дотроо цэгцлэх, чадавхыг бэхжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах зэрэг үйл ажиллагаанд түлхүү анхаарал хандуулж байна. Тухайлбал 1 дүгээрт салбарт ашиглаж байгаа эрүүл мэндийн бүртгэлийн маягтыг цахим хэлбэрт шилжүүлэх, салангид зэрэгцээ урсгалаар цугларч байгаа эрүүл мэндийн өгөгдлийн загварыг стандартчилан мета дата системийг хөгжүүлэх үйл ажиллагааг хийж байна. 2 дугаарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулан, иргэн оршин буй газраасаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг саадгүй авах боломжийг бүрдүүлэх зорилгоор зайн оношилгооны төвийг байгуулан, үйлчлүүлэгчийн дүрс оношилгооны зургийг илүү өндөр нарийвчлалтайгаар эмчид уншигдах, эмч цаг алдалгүйгээр шинжилгээний хариуг олох боломжийг бүрдүүлээд байна. 3 дугаарт эмийн чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор импортоор гаалиар орж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээ, үнэ, бар код зэргийг цахимаар бүртгэлжүүлэх, эмийн санд жижиглэнгээр худалдаалагдаж байгаа эмийн үнийг НӨАТ-ын системтэй холбох, эмийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх үйл ажиллагааг Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн төв зэрэг байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

4 дүгээрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэнд цаг алдалгүй хүргэх зорилгоор цахим эмнэлэг байгуулах ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн эрчимт эмчилгээний өрөөний амин үзүүлэлт, амьсгалын аппаратыг нэгдсэн төвөөс хянаж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, орон нутгаас Улаанбаатар хот дахь төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг зорин ирэх иргэнд цахимаар эмчийн эхний үзлэг шинжилгээний цагийг товлон өгч, үйлчилгээний чирэгдлийг арилгах зэрэг ажлуудыг нэгтгэн зохион байгуулалтад оруулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар 1200 гаруй иргэн цахимаар эмчийн үзлэг зөвлөгөөг өгөөд байна. 5 дугаарт эрүүл мэндийн мэдээ мэдээллийг хэрэглэгчид илүү ээлтэй, нээлттэй болгох зорилгоор эрүүл мэндийн мэдээллийг нээлттэй dashboard хэлбэрээр харах, боловсруулсан мэдээллийг татаж авч ашиглах боломжийг бүрдүүлээ. Өнөөгийн байдал, өнөөдрийн байдлаар нийт 20 гаруй нээлттэй мэдээллийн dashboard-ийг нээлттэй хэлбэрээр байршуулсан. 6 дугаарт нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр иргэний гар утсанд мессежээр болон ИМонгол платформ болон хүн амын дунд өргөн хэрэглэж байгаа мобайл аппликэйшнээр дамжуулан иргэнийг эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд дуудах, үр дүнг эргэн мэдээлэх, эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох, өрх, сумын ЭМТ-үүд зорилтот бүлгийн иргэдийг заавал эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамруулах тогтолцоог нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

7 дугаарт эрүүл мэндийн салбарт цугларч байгаа дүрс оношилгооны зураг, эмчийн дүгнэлт зэрэг өгөгдлийн тодорхой хэсгийг эмч, эрдэмтэн, судлаач нарт ашиглаж болохуйцаар ил болгон хиймэл оюун ухаан, машин сургалтын технологийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд холбогдох журмын төслийг боловсруулан хэлэлцүүлж, санал авч байна. 8 дугаарт эмнэлгийн дотоод үйл ажиллагаанд ашиглаж байгаа цахимын программ хангамжийн өгөгдлийн давхардлыг арилган, ажлын ачааллыг бууруулах, бүртгэл тайлан, гар ажиллагаатай үйлдлүүдийг автоматжуулах, эко системийг бүрэн цахимжуулахаар процессын зураглалыг хийх ажил үргэлжилж байна. 9 дүгээрт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээ авах тандалт судалгаа хийх зорилгоор Шуурхай удирдлагын төвийг ЭМЯ-нд байгуулсан. Уг төв нь шуурхай удирдлагын багийг эрүүл мэндийн өгөгдлөөр бодит цагийн горимоор хангаж хариу арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулах удирдлагын төв болно. 10 дугаарт мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөцийг сургах, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийн үнэлгээ хийх арга аргачлалыг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, хүний нөөцийг чадавхжуулах, үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Бид цаашид эрүүл мэндийн салбарын их өгөгдлийг бий болгох, үүний тулд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг цахим системд бүрэн нэгтгэх, өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг сайжруулах, мэдээллийн технологийн чиглэлээр хүний нөөцийн цалин урамшуулалтыг нэмэгдүүлэх, иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цахимаар авах боломжийг илүү өргөжүүлэх чиглэлд илүү анхаарч ажиллаж байна. Мөн салбарын их өгөгдөлд суурилсан эмчилгээ оношилгооны үр дүнг машин сургалт хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан хүртээмж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх технологийн шийдлүүдийг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүд ээ, та бүхэндээ эрүүл мэндийн салбарын цахимжилтын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар товч танилцууллаа. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт тавих гишүүд нэрсээ өгнө үү? Ундрэм гишүүн Анар гишүүний ирцтэй юун дээр гарч ирж байна та. Тийм үү? Энэ дээр яагаад Анар гээд гараад ирэв? Түрүүчийн. Энд гарч ирж байна. Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат, Ундрэм, Пунсалмаа, Золжаргал нэрсээ өгсөн байна. Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Мөнхсайхан сайддаа баярлалаа. Тэгээд ер нь манай эрүүл мэндийн салбар ЭМЯ энэ цаг хугацаанд нэлээн үр дүнтэй сайн ажиллаж байгаа салбаруудын нэг гэж үзэж байгаа. Тэгээд энэ салбарын цахимжилтын асуудал дээр бас нэлээн ахицтай явж байгаа гэж ойлгож байна. Гэхдээ бас нэлээн хэд хэдэн асуудлуудын талаар улам чамбайруулах, улам сайжруулах чиглэлээр ажлууд хийхээр ингээд төлөвлөж байгаа юм байна.

Миний нэг сонирхож байгаа зүйл ер нь энэ цахимжилт танай энэ салбарын хувьд хэдэн хувьтайгаар хэрэгжиж байна гэж бодож байгаа юм бэ, ер нь бид эцсийн бүлэгт 100 хувьтай болоход одоогоор хэд байгаа юм бэ? Ингэхийн тулд ямар асуудлууд жишээ нь тулгарч байна вэ бүрэн гүйцэт болгохын тулд? Эрх зүйн хувьд байна уу, эдийн засгийн хувьд байна уу, хүний нөөцийн хувьд байна уу энэ тал дээр аль тал дээр нь бид анхаарал хандуулах гэх юм уу, жишээ нь тантай хамтарч

ажиллах ийм хэрэгцээ шаардлага үүсээд байна гэдэг талаар 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт энэ цахимжилтын үйл ажиллагаа маань өөрөө орон нутагт, хөдөө орон нутгуудад ер нь хэрхэн ямар хэмжээнд явж байна вэ? Улаанбаатар хот хөдөө хоорондын ялгаа байна уу? Хэрвээ байвал юун дээрээ энэ асуудал нь үүсээд байна гэдэг талаар сонирхмоор байна.

3 дугаарт орон нутагт байгаа энэ мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн тоо цөөн байдаг. Энэ нь төгсөж байгаа мэргэжлийн боловсон хүчин орон нутагт очиж ажиллах эсэхтэй холбоотой бас байгаа байх. 2 дугаарт нь цалин хангамж, нийгмийн асуудал. Танай дээр сая ингээд танилцуулга дээрээс харахад мэдээллийн технологийн инженер 1,2 сая гэхэв үү, би сая буруу харчхав уу нэг иймэрхүү цалин өгдөг юм шиг байна. Төрийн захиргааны зарим байгууллагууд энийг би Цахим яамныхнаас асуух гээд байгаа юм. Төрийн захиргааны зарим байгууллагууд мэдээлэл технологийн ажилтнаа нэг итгэлцүүр, нэг цалингийн итгэлцүүрээр ингээд бодоод арай өөр түвшинд цалинжуулаад байдаг санагдаад байх юм. Жишээ нь орон нутгийн Тамгын газрын мэдээлэл технологийн инженер 3,5 сая төгрөгийн цалин авдаг билүү. Ийм итгэлцүүр жишээ нь манай аймагт намайг орон нутагт ажиллаж байхад байсан. Энийг энэ эрүүл мэндийн салбар луу яаж болдоггүй юм уу, нэвтрүүлж болдоггүй юм уу гэдэг нэг ийм нэг асуулт. 4 дүгээрт нь ер нь, нэг минут нэмчихье.

Ж.Золжаргал: Микрофон минут нэмж өгье.

Ц.Мөнхбат: Ер нь бид энэ эрүүл мэндийнхээ салбарыг цахимжуулснаараа жишээ нь энэ эмч, эмнэлгийн ажилтнуудын хүний нөөцийн хэмжээнд яаж өөрчлөлт орох юм бэ, өөрчлөлт орох юм уу? Бид хэдийгээр ингээд цаг хугацаа, орон зай ингээд л зөндөө тийм давуу талууд үүсгэчихсэн. Нөгөө талдаа яг танай салбарын энэ эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд өөрчлөлт гарах уу, нэмэгдэх үү аль эсвэл хасагдах уу гэдэг ийм асуултуудыг асуух нь байна.

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайд асуултад хариулна.

Т.Мөнхсайхан: Манайхан сонсож байгаад дутуу зүйлүүдийг маань нэмээд хариулаарай. Ер нь зүгээр манай улсын эрүүл мэндийн салбар цахимжаад болчихлоо гэж тооцоолохын тулд бид ер нь бүх улсынхаа бүх иргэдийг эрүүл мэндийн ID дугаартай болгоод, бүх иргэдийн эрүүл мэндийн мэдээлэл төрсөн цагаасаа хойш үхэх хүртлээ ингээд бүх мэдээлэл нь байнгын хадгалаатай байж байдаг энэ мэдээллийн санг бид бий болгож чадсанаараа ер нь манай эрүүл мэндийн салбар тусламж үйлчилгээний чиглэлд ер нь цахимжилт боллоо гэж авч үзнэ 1 дүгээрт.

2 дугаарт бидэнд өнөөдөр хэрэглэгдэж байгаа энэ бүх цахимжилттай холбоотой энэ программ хангамжууд бүгдээрээ нэг стандартын дагуу, нэг нормын дагуу хоорондоо бүгдээрээ мэдээллээ солилцдог энэ тогтолцоо маань бий болгосны үндсэн дээр бид ер нь цахимжилт боллоо.

3 дугаарт бид энэ манай улсад хэрэглэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл маань ер нь гаалиар орж ирэхдээ бүх мэдээлэл, бүх бүртгэлүүд бар кодоороо бүртгэгдээд, эргээд хаана, ямар иргэнд очоод хэрэглэгдчихэв, өнөөдөр манай улсын хувьд ямар эмийн нөөц багатай байна, дутагдалтай байна, хэзээ, ямар эм,

эмнэлгийн хэрэгслийн нөөц багасах байна гэдэг энэ бүх мэдээллээ харж хянаж чаддаг ийм тогтолцоог бид бий болгож чадсанаараа манай эрүүл мэндийн салбар ер нь цахимжилт маань болж байна гэж ингэж бид үзэх ёстой.

Тэрний тулд ер нь манай улсад өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлууд маань яг тийм ийм цогц энэ үндсэн энэ иргэдийн мэдээллийн дата баазыг бий болгох, бидний ярьдаг big датаг бий болгох чиглэл рүүгээ биш, илүү их энэ бүртгэл, мэдээлэл энэ программ хангамж тал руугаа явчихсан учраас бид нарын хийж байгаа ажлууд маань илүү их суурь шинэчлэл өөрчлөлтийг хийх рүү чиглээд явж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр өнөөдөр бид саяын ярьсан түвшинд хүрэхэд ер нь 60 орчим хувьтай явж байна уу гэж хэлж болно. Бид ер нь бид нарын төлөвлөлтөөр ирэх оны төгсгөл гэхэд бид ер нь бүх иргэдийнхээ ингээд эрүүл мэндийн мэдээлэл нь байж байдаг ийм тогтолцоо руугаа ингэж ороход бэлэн болно гэдэг үүднээс бид энэ цахимжилтынхаа ажлыг хийж байна.

Бид нарын хамгийн гол өнөөдөр нэг стандартад оруулах энэ ажил маань мета датагаа бий болгох, энийгээ бүрдүүлэх бүх энэ маягтуудыг цахим болгох, энэ 136 төрлийн маягыг цахим болгох, тэрний тулд энэ 4 мянга гаруй төрлийн энэ талбарыг цахимд оруулж, нэг стандартад оруулах энэ ажил маань ер нь нэлээн урагштай хийгдээд, зарим нэг газарт бас туршилтын байдлаар хийж бид энэ бүртгэл мэдээллүүдээ хийж эхлээд байна. Тэгээд энэ манай салбарт энийг хийж хэрэгжүүлэхэд гол тулгамдаж байгаа асуудал яалт ч үгүй хүний нөөцийн асуудал байна. Энэ дээр энэ сайн мэдлэг, чадвартай энэ IT мэргэжилтнүүд яалт ч үгүй манай салбарт төдийгүй дутагдалтай байна л даа. Тэгээд ялангуяа манай салбарт ажиллахад энэ ажилтнуудын маань цалин мөнгөнийх нь хэмжээ үнэхээр бага байгаад байна. Тэгэхээр цаашдаа бид энэ эрүүл мэндийн салбарт өндөр IT өндөр мэдлэгтэй энэ хүмүүс ажиллах энэ боломжийг бүрдүүлсэн энэ цалин мөнгөний хэмжээг нь сайтар шинэчилж тогтоож өгөх ийм зайлшгүй шаардлага байна.

Хөдөө орон нутагт ер нь манай цахимжилтын ажил ер нь бүх сумуудын түвшинд хийгдээд явж байгаа. Гэхдээ эд маань бүгдээрээ л түрүүний ярьсан нэг стандартын дагуу мэдээллээ солилцох асуудал нь учир дутагдалтай байна. Энэ нь зөв болоод ирэхээр болчихоор байгаа. Дээрээс нь бид энэ цахимжилтыг.../минут дуусав/

Ж.Золжаргал: Цаг нэмж өгье.

Т.Мөнхсайхан: Цахимжилтаа бид ер нь хурдан шуурхай яг бодит байдлаар шийдэж цахимд бүрэн шилжиж чадсанаар хүний нөөцийн хувьд бид нарт нэлээн их давуу талууд гарахаар байгаа. Ер нь хүний нөөцийн хэмнэлт хийж болохоор байгаа. Жишээ нь өнөөдрийн байдлаар бид нарын хувьд оруулчихсан байгаа бид зайн оношилгооны төвийг оруулсан байгаа. Энэ дээр 21 аймагт хийгддэг нөгөө MRI, компьютер томограф, рентген зураг авч байгаа бүх аппаратууд холбогдсон. Энэ төв дээр ажиллаж байгаа эмч энэ 21 аймагт 24 цагийн турш хийгдэж байгаа энэ зургуудыг уншиж хариу бичих боломж бүрдэнэ. Тэгэхээр аймаг бүрд заавал энэ төрлийн эмч 24 цагаар ажиллаад байх ийм шаардлага байхгүй болно. Улсад Улаанбаатарт ч гэсэн эмнэлэг болгон дээр ийм дүрс оношилгооны нарийн мэргэжлийн эмч хоноод байх шаардлага байхгүйгээр улсын хэмжээнд энэ зайн оношилгооны төв дээр энэ хариугаа бичдэг, түргэн шуурхай үйлчилдэг боломж бүрдэнэ гэх мэтчилэн маш олон давуу талууд.../минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа би тодруулаад асуучихъя гэж бодож байна. Мөнхбат гишүүн өөрөө энэ аймгийн Засаг дарга байсан хүн. Орон нутгийн IT мэргэжилтний нэмэгдэл индексжүүлээд ингээд 3,5 сая төгрөгийн цалин авдаг байсан гээд мэдээд байна л даа. Тэгээд энэ эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгаа хүмүүс 1,2 гэхээр чинь тэнд ямар боловсон хүчин ажиллах вэ дээ. Энэ талаар тэр индексийг нь ашиглах ч юм уу арга зам ямар боломж судалсан юм байгаа бол? Ажлын хэсгээс хариулт хэлэх хүн байна уу, хэддүгээр микрофон бэ? Дугаар 1 нээж өгнө үү?

П.Оюунцэцэг: Стратеги, төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг. Ерөнхийдөө манайх төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ ялангуяа энэ цахимын энэ юунд IT мэргэжилтнүүд дотор ТҮ7 гээд юу төрийн үйлчилгээний 7 гэсэн энэ ангилалд явж байгаа. Тэгэхээр ЗГ-ын тэр цалингийн индексийн асуудал зөвхөн удирдах ажилтнуудынх нь л 1, 2 хүн дээр байгаа болохоос биш яг энэ манай салбарын нийт IT-н ажилтнууд дээр ТҮ-хээ юугаар явж байгаа юм цалингийн тогтолцоогоор явж байгаа юм.

Ж.Золжаргал: Цахим, цахимынхнаас хариулт өгөх үү? Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. Микрофон нээгээд өгчихлөө Алтан-Од даргын, 5 дээр очоод суучих уу даа та. Манай юуныхан тэр 5 номерыг урд нь аваачаад тавьчхаарай.

П.Алтан-Од: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Цахим хөгжил, инновац байнгын хорооны яамны ТНБД Алтан-Од. ЗГ-аас 2023 оны 5 сарын 31-ний өдөр итгэлцүүр тооцох тухай 213 дугаар тогтоол гаргасан. Энэ хүрээндээ төрийн захиргааны болоод төрийн захиргааны төв байгууллагуудын удирдах албан тушаал дээр түмт буюу ТҮ-ийн хөдөлмөрийн гэрээгээр ТЗ-р биш ТҮ-ийн зэрэглэлээр хөдөлмөрийн гэрээ байгуулах зарчмаар итгэлцүүр бодож, гүйцэтгэх болоод 2 албан тушаал дээр ингээд байгууллага болгон дээр нь 75 байгууллагын дээр квот тогтоож өгсөн байгаа. Энэ хүрээндээ аймгийн ЗДТГ бас ордог. Мөн төрийн захиргааны яамнууд ордог. ЭМЯ болоод холбогдох төрийн байгууллагуудаас салбарын байгууллагуудаас энэ чиглэлийн мэдээлэл технологийн ажилтны орон тоог энэ итгэлцүүр дээр нэмэх квотыг тогтоож өгөх талаар маш олон хүсэлтүүд ирдэг. Тэгээд мэдээж энэ мэдээлэл технологийн ажилтан нь өндөр ур чадвар эзэмшсэн нөхдүүдийг энэ салбар дээрээ тогтоож барих, төрийн захиргааны ерөнхий болоод тусгай шаардлагыг өгөхгүйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх чиглэлээр бас ийм ажиллах зайлшгүй ийм нөхцөл шаардлага байдаг. Бид яг энэ 2025 оны хэмжээнд судалгааны ажлуудаа аваад, ЗГ-ын холбогдох шийдвэрийг оруулна. Ингэхдээ төрийн захиргааны төв бүх байгууллагуудаас салбарын байгууллагуудаас нь түмт буюу тэр чиглэлийн мэргэжлүүдийг нэгтгэж оруулахаар ингэж бас ажиллаж байгаа.

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүн тодруулж асууна, микрофон нээж өгнө үү.

Ц.Мөнхбат: Энэ сая сайдын хариулт дунд гарлаа. Хөдөө орон нутаг нэг стандартын биш учраас учир дутагдалтай юм байдаг гэсэн тийм санаа цухуйлгалаа л даа. Энэ нь тэр нэг нэгдсэн программ хангамжтай байгаа юм уу аль эсвэл тэр программ хангамжийг хүлээж авч ажиллуулж байгаа тэр тоног төхөөрөмжийн зөрөөтэй, нөгөө хуучирсан шинэ, хуучнаасаа болоод ийм юм байдаг юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт тэр саяын тэр төрийн захиргааны байгууллагуудад ажиллаад байгаа арай өндөр цалин аваад байгаа IT-н мэргэжилтнүүдийг эмнэлгүүд энэ эмнэлгийн байгууллагууд чинь нөгөө гүйцэтгэлийн санхүүжилтээр явдаг. Тэр гүйцэтгэлийн санхүүжилт дээрээ тэндээсээ олж байгаа тэр мөнгөнөөсөө өөрсдөө дотоод журам байдаг юм уу эсвэл сайдын тушаалд байдаг юм уу тийм юмаар тэр арай адилхан тэр 3,5 саятай дүйцэхүйц цалин аваад явж болох тийм зохицуулалт байдаггүй юм уу гэж ийм 2 асуулт асууя.

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайд хариулах уу.

Т.Мөнхсайхан: Тэр цалингийн хувьд ялангуяа орон нутгийн эмнэлгүүд маань гүйцэтгэлийн санхүүжилтэд ороод нэг үеэ бодвол зарцуулах санхүүжилттэй болчихоод байгаа юм. Гэхдээ энэ дээр яг тэр нөгөө шатлалынх нь ангиллынх нь дагуу цалингаас 20 хувиас илүү цалин олгох тийм боломжгүй зохицуулалтыг ингээд Сангийн яамнаас систем дээр нь хийгээд өгчихсөн. Тэгээд ямар нэгэн байдлаар аргалаад илүү цалин мөнгө олговол эргээд аудитаас сөрөг дүгнэлт аваад байдаг ийм тал байгаа. Тэгэхээр энэ дээр нь бид бас зохицуулсан тийм журам юмнуудыг нь Сангийн яамтай ярьж байгаад шинэчлээд ингээд гаргаж өгөх ийм ажил маань хийгдэж байгаа. Тэгэхээр зарим нэг эмнэлгүүд дээр боломжтой, зарим нэг эмнэлгүүд маань ингээд цалин мөнгийг нь нэмэгдүүлээд явж байгаа зүйл байгаа.

Тэр яах вэ программ хангамжийнхаа хувьд манайх анхан шатан дээр болон лавлагаа шатлал дээр хэрэглэж байгаа программ хангамжууд дээр маш олон төрлийн программ.../минут дуусав/

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайдын цаг нэмж өгье, микрофон нээж өгье.

Т.Мөнхсайхан: Тэгээд энэ олон программ хангамж нь хоорондоо тийм уялдаа холбоо байхгүй, хоорондоо тийм мэдээллээ солилцох ийм боломжгүй болчихоод байгаа юм. Тэгээд энийг нэгдсэн 1 журамд оруулъя гэхээр ингээд энэ дээр маш олон төрлийн компаниуд энэ дээр программ хөгжүүлэлт юмнууд хийчихсэн байдаг. Ингээд эргээд Ерөнхий сайдын түрүүний ярьсан тэр ажлын хэсгээр энэ орон зайг чөлөөтэй энэ хувийн хэвшлийнхэнд боломжийг нь олгоно гэсэн ийм тушаал шийдвэрүүд байгаа. Тийм учраас бид ер нь ямар стандарт норм, журмыг хангасан байх юм бэ. Түрүүний ярьсан тэр бид мета датагаа эргэж тэд нартаа ашиглуулаад, ямар стандартыг хангасан байх юм бэ гэдэг шаардлагыг нь тавиад, ЭМЯ-наас тэр шаардлага хангаж байгаа компаниудыг нь л зарлаад явъя. Тэрийг нь энэ орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд маань суулгаад, ашиглаад явбал эргээд мэдээллээ солилцдог ямар нэгэн тийм хүндрэл чирэгдэл гарахгүй энэ боломж бүрдэх юм байна лээ. Энэ ажил маань нэлээн хийгдээд.../минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа. Энэ ялгамжтай цалингийн зэрэглэл байвал угаасаа энэ цахим шилжилт хэрэгжих боломжгүй шүү дээ. 1,2 сая төгрөгөөр ажиллана гэж юу байх вэ дээ. Тэгэхээр энийгээ яаж зохицуулах вэ гэдгээ Сангийн яамтайгаа, салбарын яамтайгаа түргэхэн шиг яриад, шаардлагатай бол Байнгын хороон дээр бидний зүгээс яаж дэмжиж болох вэ, яг асуултаа томъёолоод оруулж ирээсэй гэдгийг хэлмээр байна. Пунсалмаа гишүүний асуултыг авъя. 34 дүгээр суудлын микрофон нээж өгнө үү.

Б.Пунсалмаа: Сайн байцаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. ЭМД-ын салбар дээр ер нь нэг реформ хийх цаг нь болчихжээ. ЭМД-ын сангийн орлого, эрүүл мэндийн сангийн даатгалын сангийн зарлага 2 харьцуулахад үнэхээр харьцаа

үнэхээр хол байна. Тийм учраас эмнэлгийн цаг олдохгүй, жилийн эцэст зарим эмчилгээнүүд дараа жилээ хүлээдэг ийм хүндрэлтэй нөхцөл байдал үүсчхээд байна. Тэгэхлээр ЭМД дээр энэ сайдыг нь байгаа дээр реформын талаар яримаар байна. 2 шатлалтай ЭМД-ын тогтолцоогоо хиймээр байна. Нэг шатлал нь болохлоор суурь даатгалын тогтолцоо буюу эмчид үзүүлэх, онош авах, тогтоолгох. 2 дахь шатлал нь болохлоор нэмэлт даатгал буюу хамтын төлбөрийн системээрээ энэ бол эмнэлэгт хэвтэх, өндөр төлбөртэй хагалгаагаа хийлгэх ч гэдэг юм уу ийм системийг бид холбохын тулд өнөөдөр энд цахим системийн энэ асуудлын хүрээнд энэ асуудал яригдаж байгаа.

Яагаад гэхлээр цахимын шилжилтийн хүрээнд бид картын төлбөр тооцооны хэлбэрээр нэмэлт даатгалын тогтолцоог баяжуулах боломжтой. Жишээлбэл нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувийн буцаалтыг зарим иргэд хэрэглэдэггүй. Энэ 2 хувийнхаа буцаалтыг эргүүлээд энэ ЭМД-ын сан руугаа оруулдаг. Мөн бас зарим картуудынхаа бид хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрэглэхгүй энэ илүүдээд хэмнэлт гаргах энэ карт дээр байгаа энэ боломжуудаа бид ЭМД руу оруулж ирдэг ийм тогтолцоогоо бид цахим энэ шилжилтийн хүрээнд хиймээр байна энийг.

2 дугаар юм нь болохлоор эрүүл мэндийн ер нь цахим шилжилт харьцангуй дажгүй сайн хийгдэж байгаа гэж би үзэж байгаа. Жишээлбэл бид эмийн жор, дүрс оношилгооны дүгнэлт, шинжилгээний хариу гээд олон зүйлүүдийг авч болж байгаа. Эмийн жор дээр би нэг зүйл хэлмээр байна. Эмийн жорыг эмч жор бичээд явуулж байгаа. Эмийн сан руу автомат жор ирж байгаа. Гэхдээ тэр хүмүүс маань кодоо мартдаг асуудлаас болоод эргээд нөгөө кодыг нь эмч нь ингээд жорын цаасан дээр код бичиж өгч явуулаад байдаг. Энэнийхээ оронд тухайн хүний регистр дугаар ч юм уу, тухайн иргэний нэр усаар нь ингээд биччих юм бол энэ бүтэн эмийн жорын хувьд бүтэн шилжилт хийх ийм боломж байна гэх мэтчилэн ийм жижиг, жижиг засварууд байж болж байна.

Жишээлбэл эмчид үзүүлж байх явцад 10 минут түр дунд нь хүлээлгэдэг. Гэтэл зарим эмчид өвчтөн эмчдээ маш хурдан хөнгөн хэлбэртэй өвчтөн байгаа учраас богино хугацаанд уулзаад гарах эмчийн цаг авах энэ бололцоо дээр 5 минут хүлээх ийм боломж бололцоог нь нээж өгмөөр байна гээд ийм жижиг жоохон засварууд байгаа. Энэ цахим шилжилт энэ НӨАТ-ын 2 хувийн буцаалтыг холбох талаар та бүхэн минь ажиллаарай гэж ингэж хүсье.

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайдын микрофон нээж өгнө үү.

Т.Мөнхсайхан: Ер нь гишүүн маань санал хэлж байна. Саналыг хүлээж авлаа. Цаашдаа анхаараад явъя. Ер нь ЭМД-ын сан дээр зүгээр нэг жижиг тайлбар хийж байхад тэр 2019 онд 500 гаруй тэрбум төгрөг байсан, одоо 2025 онд 2,3 их наяд болсон гэдэг чинь энэ чинь их өөр ойлголтын тоо байхгүй юу. Бид чинь 2021 оноос хойш гүйцэтгэлийн санхүүжилт шилжсэн гээд, ЭМД-ын санд төвлөрч байгаа мөнгө, төрийн сангаас эргээд даатгалын санд төвлөрч байгаа мөнгө бүгдээрээ нийлээд нэг эх үүсвэрийн худалдан авалт болоод, эргээд эрүүл мэндийнхээ тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байгаа нийт санхүүжилтийн дүн ийм байгаа. 2019 оны 500 гаруй тэрбум төгрөг гэдэг чинь зөвхөн иргэдээс цугларсан нөгөө шимтгэлээс цугларсан ЭМД-ын санд цугларсан мөнгөний дүн юм байгаа юм. Тэгэхээр энийг маш сайн ялгаж, салгаж ойлгох хэрэгтэй.

Бид 2021 онд гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжсэнээрээ бид энэ даатгалын сангийн эхний ээлжийн реформ нь хийгдсэн. Энэ үеэс хойш манай эрүүл мэндийн

салбар маш сайн мэдээллээ цуглуулдаг болсон байхгүй юу нэг үеэ бодвол. Өмнө нь ерөөсөө байдаггүй байсан, цуглардаггүй байсан энэ оношны хэдэн хүн үйлчлүүлээд байгаа юм, ямар оношоор их үйлчлүүлээд байгаа юм, эмчилгээ үйлчилгээ нь ямар байгаа юм гээд бүх мэдээллээ цуглуулж аваад энэ дээрээ үндэслэсэн бид бодлогоо хэрэгжүүлээд ирэхээр хийж хэрэгжүүлж байгаа бодлогууд маань нэлээн оновчтой болоод байгаа.

Цаашдаа бид ер нь эрүүл мэндийн салбарын энэ цогц хуулийн шинэчлэлийг зайлшгүй хийж хэрэгжүүлэх шаардлагатай байгаад байгаа юм. Өнөөдөр манай эрүүл мэндийн салбарт зарцуулагдаж байгаа нийт санхүүжилт чинь ДНБ-ийхээ 3 хувьтай тэнцээд байгаа. Тэгэхээр дэлхий дээр тооцоо судалгаагаар олон улсын байгууллагуудын судалгаагаар доод тал нь 6 хувьтай байж санхүүжилт нь хүрнэ гэдэг ийм тооцоолол байдаг. Бид тэгэхээр ер нь тийшээгээ л явж байж манай эрүүл мэндийн салбарын санхүүжилт ер нь шийдэгдэх юм байгаа юм. Тэрний тулд бид энэ манай салбарын энэ цогц хуульд нэлээн том шинэчлэлт, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль энэ бүгдэд бид өөрчлөлтүүдийг оруулж байж бид энэ тусламж, үйлчилгээг өнөөдрийн байдлаас илүү дараагийн түвшинд хүргэх энэ боломж бүрдэх юм байгаа юм. Тэгээд энэ тал дээр бид ажиллаж байгаа. Ер нь энэ намрын чуулганаар энэ эрүүл мэндийн цогц хуулиудаа өргөн барихаар бид ер нь хуулийн төслүүд дээрээ ажиллаж байгаа. Тэр цахим жорыг кодоор олгодог, бас регистрийн дугаараар олгоод явж байгаа байх. Тэр боломжууд нь байгаа. Тэрийг та хэд тодруулаад хэлээдхээч.

Ж.Золжаргал: Ажлын хэсгээс 2 дугаар микрофон.

Э.Мягмар-Өлзий: Сайн байна уу. Мягмар-Өлзий ЭМЯ-ны Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтсийн дарга. Цахим жорны хувьд иргэд ИМонголиа аппликэйшнээр жишээлбэл аппликэйшнтэй бол аппликэйшнаараа ороод үзэж болж байгаа: Аппликэйшнгүй тохиолдолд яг код өгөөд байгаа. Энийг бид дараагийн хувилбараар нь таны хэлсний дагуу нэлээн сайн судалж нэвтрүүлэх талаар ажиллая.

Ж.Золжаргал: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Ундрамын микрофоныг нээж өгнө үү.

Ч.Ундрам: Энэ эрүүл мэндийн салбарын цахим шилжилт өмнөх парламентаар ч гэсэн зөндөө яригдсан, яригддаг л байсан асуудал. Тэгээд өмнөх парламентын үед нэг Дэлхийн банкны төслөөр эрүүл мэндийн салбарын энэ цахим шилжилтийг хийнэ, гайхамшигтай сайхан нэг программтай болгоно гээд том дүнтэй төсөл орж ирээд, тэгээд тэрнээс болоод зарим нэг албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилтэй компаниа оруулаад, ингээд мөнгө нь буцаад банк руугаа татагдчихсан. Дэлхийн банк энэ гэрээгээ цуцлаад, ингээд мөнгөө буцаагаад авчихсан ийм хэрэг байдаг, ийм асуудал байдаг. Энэ бол эрүүл мэндийн салбарын энэ цахим шилжилтийг маш томоор ухраасан ийм гэмт хэргийн шинжтэй асуудал гэж би бодож байна. Энэ яг ямар түвшиндээ энэ хэрэг явж байгаа вэ? Зүгээр ингээд энийг болохоо байчихлаа гээд хаяад, дараагийн юм руугаа шууд ороод яваад байж болохгүй. Бид хариуцлага тооцдог байх ёстой. Тэгээд яг энэ мөчид Авлигатай тэмцэх газрын даргын асуудал яригдаж байдаг. Энэ бас нэг авлигын асуудал эрүүл мэндийн салбарт ингээд яригдаад явж байдаг. Тэгэхээр энийг мэдмээр байна.

2 дугаарт одоо яг байгаа энэ цахим программууд дээр чинь сумын эмнэлгүүд, өрхийн эмнэлгүүд, жишээлбэл яг өөрийнхөө тэр нутаг дэвсгэрт байгаа өвчтөний мэдээллийг шууд компьютероо нээгээд ингээд харах, авах боломж ер нь байдаг юм болов уу тэрийг мэдмээр байна.

3 дугаарт мэдээллийн аюулгүй байдал. Саяхан 1 эмнэлэг дээр хүмүүсийн био дата, нарийн нандин мэдээлэл нь задарлаа гээд л ингээд бөөн асуудал болоод байсан. Тэгэхээр энэ мэдээллийн аюулгүй байдлаа та хэд яаж хангаж байгаа юм бэ?

4-д энэ эмийн чанар. Эрүүл мэндийн сайд байгаа учраас асуучихмаар байна. Эмийн чанар маш муу байна. Энийг ард иргэд ч орон нутгаар явж байхад тавьж байна. Даралтын эм уугаад даралт нь буурахгүй, ханиадны эм уугаад ханиад нь эдгэрэхгүй байна гээд. Тэгээд сүүлдээ би өөрөө хүртэл өвдөөд эмийн салбарт ажилладаг хүнээс хүүе би энэ антибиотик уугаад байдаг эдгэдэггүй, уул нь шинжилгээ өгөөд л эмчийн жороор. Тэгсэн дандаа хуурамч антибиотикүүд зах зээл дээр байгаа, ориг эм нь тасалдчихсан байгаа, орж ирэхээр нь би хэлье гэж байгаа байхгүй юу. Энэ чинь юу гэсэн үг вэ? Тэгэхээр ард иргэддээ ингээд хор өгөөд л бид сууж байна гэсэн үг үү?

Ж.Золжаргал: 4 асуулт тавилаа. Маш чухал асуудлууд хөндлөө. Магадгүй Мөнхсайхан сайд, тэгээд цахимынхан нэмэлт хариулт өгөх байх. Мөнхсайхан сайдын микрофон нээж өгнө үү.

Т.Мөнхсайхан: Тийм. Дэлхийн банкнаас энэ эрүүл мэндийн салбарыг цахимжуулах төсөл хэрэгжээд, тэр төслийн хүрээнд бас эхлэл нь эрүүл мэндийн салбар цахимжих эхлэл нь тавигдсан. Тэгээд хамгийн гол хэсэг энэ программ хоорондын уялдаа холбоог хангах, мэдээллээ солилцдог энэ тогтолцоог бий болгох энэ процессын явцад явцад тэр Дэлхийн банкнаас хийж хэрэгжүүлж байгаа төсөл дээр учир дутагдалтай зүйлүүд гарсан учраас Дэлхийн банк энэ төслөө зогсоочихсон. Тийм учраас бид дараагийн алхмуудаа хийгээд явахаас өөр аргагүй. Бид Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр цахим хэлтэстэй болсон. Ингээд хэлтсийнхээ түвшинд бид өнөөдрийнхөө энэ шийдэх ёстой энэ асуудлуудаа бүгдийг нь шийдээд, шийдвэрлээд явж байгаа гэсэн үг. Тэр хэрэг төвөг юу болж байгаа талыг хууль хяналтын байгууллагуудаасаа та илүү тодруулбал танд илүү их мэдээлэл өгөх байх. Тэр ер нь анхнаасаа гомдол гараад, тэгээд тэр хэрэг үүсгэгдээд явсан гэж тийм ойлголттой байгаа. Тэгэхээр нэгэнт хэрэг үүсээд явчихсан зүйл дээр хууль хяналтынх нь байгууллагууд нь тэрийгээ тогтоогоод явах байх.

Цахим жорын, цахим жор гэнэ. Нөгөө энэ чанаргүй үнэтэй эмийн асуудал манай улсад их олон жил яригдаж байгаа. Энэ дээр бид бодлогын нэлээн томоохон ажлуудыг хийж байгаа. Тэгээд яг энэ дээр бас нөгөө чанаргүй эм гэдэг асуудал, тэгээд байх ёстой нөгөө норм дүрмийн дагуу бодисууд нь байна уу гээд шинжилгээ хийгээд үзэхээр тэр нь байгаад байдаг. Тийм учраас манай улсад хэрэглэгдээд байдаг ийм зүйл байгаа. Гэхдээ яг бодитоор хүн хэрэглэхээр эдгэрдэггүй, өөр чанартай эм, тариа юм уу гадагшаа яваад эмчлүүлчихээр эдгэчихдэг ийм зүйл байгаа учраас энэ дээр бид томоохон бодлогын шинэчлэл өөрчлөлтүүдийг хийж байгаа.

1 дүгээрт бид энэ эмийн олон улсын стандартыг хангасан лабораторитой болж байгаа. ДЭМБ-тай хамтраад өнөөдрийн байдлаар зураг төсөл нь хийгдчихсэн. Ингээд намар энэ ондоо багтаад энэ лабораторио ашиглалтад оруулбал бид бүх

төрлийн энэ чанаргүй байна гэж яригдаж байгаа эмүүдээ шинжлээд, үнэхээр шаардлага хангахгүй байгаа энэ эмүүдээ зах зээлээс гаргах энэ арга хэмжээгээ авна. Нөгөө талдаа бид өнөөдөр энэ манай улсад гаднын энэ өндөр хяналт дор байдаг ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн энэ сайн үйлдвэрүүдийн эм тариануудыг нэгдсэн хэлцлийг хийж оруулж ирэх энэ ажил маань хийгдэж эхлээд нэлээн урагштай явж байгаа. Өнөөдрийн байдлаар 30 гаруй төрлийн эм, тариа манай улсад энэ зарчмаар орж ирээд, үйлчлүүлэгчид хүрч байна. Зүгээр нэг жишээ хэлэхэд өмнө нь сахрын эмийг иргэн даатгалаас хөнгөлүүлээд 60 мянган төгрөг төлөөд сарынхаа хэрэглэдэг байсан бол өнөөдөр 6 мянган төгрөг төлөөд сарынхаа хэрэглээг хэрэглэж байгаа энэ боломж байна. Чанарын хувьд Солонгос улсад яг дотоод зах зээл дээрээ хэрэглэж байгаа эм, тариа.

Дахин нэг жишээ хэлэхэд энэ хавдрын үед хэрэглэдэг энэ хими тариа Энэтхэгийн хими эмчилгээнүүд нэлээн гаж нөлөө ихтэй, эргээд иргэдэд чирэгдэл, эрүүл мэндэд хохирол учруулж байна гэдэг ийм зүйл байдаг. Энэ дээр бид 5 төрлийн химийн тариаг энэ Солонгос улсаас шууд үйлдвэрлэлтэй нь хэлцэл хийх замаар оруулж ирээд өнөөдөр Хавдар судлалын үндэсний төв болон бусад эмнэлгүүд хэрэглээнд нэвтэрчихсэн явж байна. Гэхдээ энийг бид яг хууль номынх нь дагуу хамгийн өндөр чанартайг зах зээл дээр байж болох хамгийн хямд үнээр нь ард иргэдэд хүргэх энэ ажлыг хийж байгаа. Өнөөдөр манай улсын зах зээл дээр 4 мянга гаруй төрлийн нэршлийн эм байгаа. Энэ бүгд дээр хяналт тавьж, чанартай болгох ажлыг ирэх оны төгсгөл гэхэд.../минут дуусав/

Ж.Золжаргал: Сая тэр нөгөө сум, сумдын эмнэлэг цахим алсын зайн эмчилгээ үзлэг оношилгооны талаар асуусан. Тэр дээр хариулт өгнө үү. 2 номерын микрофон нээж өгье.

Э.Мягмар-Өлзий: Сайн байна уу. Өрх сумын эмнэлэг дээр харьяа оршин байгаа газрынхаа иргэнийг регистрийн дугаарыг нь систем дээрээ бүртгэхэд оруулахад тухайн иргэний анхан болон лавлагаа шатлал дээр авсан үйлчилгээ, ЭМД-ын төлөлт, тэгээд вакцин, өмнө нь өөр эмнэлэгт үзүүлсэн шинжилгээ гэх мэтчилний өөр эмнэлэг дээр үзүүлсэн мэдээллүүдийг харах боломжтой байгаа. Энэ дээр Цахим яам, манай Эрүүл мэндийн маш их ойрд хамтарч ажиллаж байгаа. Хамгийн гол тулгамдсан асуудал юу гэвэл цахим талаасаа нөгөө өрх, сум дээр давхардсан олон системд бүртгээд байдаг асуудлыг л бид цэгцлэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл өрх, сум дээр систем байлаа гэхэд томуугийн нэг систем, юу гэдэг юм зүрх судасны нэг систем гэх мэтчилний олон ийм функцтэй системүүдийг давхар ажил хийж ачаалал үүсгээд байдаг ажлыг бид ер нь маш ойрын хугацаанд мета дата үндсэн ангилал кодын системийг оруулж, зөвхөн нэг систем дээр бүх үйл ажиллагаагаа хийдэг болох тогтолцоо явж байгаа.

Ж.Золжаргал: Мөнхсайхан сайд нэмж хариулъя. Сая тэгэхдээ таны хариулт асуулт дээр нөгөө бүртгэл талдаа юм хэллээ шүү дээ. Үзлэг оношилгоо ингээд онлайнаар хийх тэр чиглэлээр яаж байгаа юу гэсэн асуулт байна гэж ойлгосон. Мөнхсайхан сайд нэмэлт хариулт хэлнэ.

Т.Мөнхсайхан: 1 дүгээрт тэр бүртгэлийн тал дээр нь ийм байгаа. Өнөөдөр бид яг нэг иргэн өрхийн эмнэлэг дээр очоод үзүүлэхэд тэр хүнийг оношийг тавихын тулд энэ хүн ер нь төрөхдөө хэдэн грамм төрсөн юм бэ, ямар ямар, ер нь вакциндаа хамрагдаагүй юм биш биз дээ гээд энэ бүх мэдээллийг харах тийм хэмжээний цахимжилт дата мэдээлэл бид нарт өнөөдөр байхгүй байгаа. Тэгэхээр бид өнөөдрийн гол тавьж байгаа зорилго ийм хэмжээний мэдээлэлтэй болох зорилгыг

тавьж байгаа 1 дүгээрт. 2 дугаарт өнөөдөр нэг хүн өрхийн эмнэлэг дээр очиж үзүүлчхээд 1 дүгээр эмнэлэг дээр очоод үзүүлэхээр тэр өрх дээр үзүүлсэн тэр мэдээ мэдээлэл бүх юм нь тэр 1 дүгээр эмнэлэг дээрээ очдог, эргээд өрхийн эмнэлэг дээрээ очиход 1 дүгээр эмнэлэг дээр үзүүлсэн шинжилгээнийх нь хариунууд ямар байсан юм, эргээд энэ хүнд ямар хяналт тавих юм, хэзээ эргээд үзэх юм гэдэг тэр мэдээ мэдээлэл нь байдаг энэ зүйл дээр учир дутагдалтай зүйлүүд байгаа. Энийгээ бид бүгдийг нь 100 хувь оруулж.../минут дуусав/

Ж.Золжаргал: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар Алтан-Од даргын микрофоныг нээж өгье.

П.Алтан-Од: Гишүүний асуултад хариулъя. Кибер аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулагдсан мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх, мөн эрсдэлийн үнэлгээ хийлгэхээр хуульчлагдсан байдаг. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын жагсаалтыг ЗГ-аас баталж өгсөн. Цаашид ер нь эрүүл мэндийн энэ төрлийн байгууллагууд хүмүүсийн он мэдээлэл эзэмшигч хадгалж байгаа байгууллагуудын хувьд энэ жагсаалтад зайлшгүй оруулах, эрсдэл үүсвэл яаж таслан сэргийлэх вэ гэдэг тогтолцооны асуудал дээр бид ЗГ-аар ойрын үед шийдвэр гаргуулахаар ажиллаж байгаа.

Намар таны яригдсан кэйс дээр тодорхой хэмжээний арга хэмжээ мөн манай Кибер аюулгүй байдлын зөвлөл, Нийтийн төв хамтарсан арга хэмжээ авч тухайн эрсдэл багатайгаар тухайн халдлагыг таслан зогсоосон. Цаашид бас ер нь улс орнууд эрүүл мэндийн тогтолцооны асуудал хүний хувийн мэдээллийг хадгалж байдаг кибер террор халдлагад зорилго нь мөнгө нэхэмжлэх, санхүүгийн тодорхой эх үүсвэрээрээ шийдүүлэх гэх мэтчилэн асуудлууд байдаг. Мөн Азид энэ чиглэлийн.../минут дуусав/

Ж.Золжаргал: Алтан-Од дарга ЗГ-аар шийдүүлэхээр ажиллаж байгаа гэсэн шүү дээ. Тэр нь яаж ажиллаж байгаа талаараа нэг нэмээд тайлбарлаад өгөх үү, микрофон нь.

П.Алтан-Од: Цаашид энэ эрүүл мэндийн байгууллагууд тэр тутмаа энэ хувийн эмнэлгүүд тэр 210 хэдэн жагсаалтад ороогүй байдаг. Тэгэхээр энд лабораторийн үзлэг хийж байгаа, эмчилгээ оношилгоо хийж байгаа хүмүүсийн мэдээллийг хадгалж байгаа байгууллагуудыг салбараар нь ангилж тэр онц чухал дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад оруулах асуудал хөндөгдөж байгаа. Тэгэхээр мөн финтекийн байгууллагууд, бусад байгууллагууд ч гэсэн энэ цар хүрээнд орж жагсаалтыг шинэчлүүлэхээр судалгааны ажлууд хийгдэж байгаа.

Ж.Золжаргал: Ер нь эмнэлгүүд 210 гаруй эмнэлэг жагсаалтад ороогүй байгаа учраас жагсаалтад нь нэмж оруулах юм байна. Тэгэхээр нөгөө эрсдэлийн үнэлгээ, аудитын ажлууд нь хийгдэх нь. Тэгэхээр эрсдэл нь буурна гэж ойлгож байна. Зөвхөн, нэмж хариулъя гэж байна.

П.Алтан-Од: Кибер аюулгүй байдлын тухай хуулиар энэ онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд өөрсдөө хугацаатайгаар эрсдэлийн үнэлгээгээ заавал хийлгэх ёстой, тайлангаа ирүүлэх ёстой, мөн аудитын үнэлгээ хийлгэж, тайлан ирүүлэх ёстой. Тэгээд бас цаашид нөгөө ямар асуудал үүсчхээд байна вэ гэдгийг өөрсдийгөө тодорхойлох боломжгүй учраас манайхаас зөвшөөрөл олгосон хуулийн этгээдүүдээр энэ чиглэлийнхээ үйлчилгээнүүд дээр анализ

хийлгэх, аудит хийлгэх ийм зайлшгүй шаардлагууд байдгийг байнга сургалт шинэ хууль, эрх зүйн орчин бий болсонтой холбоотойгоор мэдээллүүд олон давтамжтайгаар хийгдэж байгаа.

Ж.Золжаргал: Ундрам гишүүн тодруулж асууна.

Ч.Ундрам: Дэлхийн банктай холбоотой хэргийн асуудлаар энэ чинь Монголын ард түмэн энэнээс болоод хохирчхоод байна шүү дээ энэ асуудлаас болоод. Тэгэхээр нэхэмжлэгч байгууллага нь ЭМЯ байх ёстой байхгүй юу. Тэгээд энэнийхээ араас хуульчаа томилоод, хуулийнхаа хэлтсийг томилоод араас нь ингээд хөөцөлдөх ёстой байхгүй юу. Тэрнээс түүгээрээ ингээд түүгээрээ явж байгаад тэндээсээ асуугаарай гэж болохгүй байх Мөнхсайхан сайд. Араас нь та хэд хөөцөлдөөд ямар түвшинд байгаа юм, прокурор луу шилжсэн юм уу, шүүх рүү шилжсэн юм уу гээд ингээд явахгүй бол араас нь хэн явах юм бэ ингээд хаячихвал.

Ж.Золжаргал: Ундрам гишүүн санал хэллээ. Би энэ Дэлхийн банкны 19,5 сая долларын төсөл байх миний санаж байгаагаар, 20-иод сая долларын төслийг эрүүл мэндийн салбарын цахимжилтад зориулаад хэрэглэе гэсэн чинь авч хэрэглэж чадахгүй байсаар байгаад ингээд зөрчил үүсээд алдчихсан. Тэгээд ер нь өнгөрсөн хугацаанд тэр ажлын даалгавар дээр ч тэр, сонгон шалгаруулалт дээр ч тэр салбарынх нь мэргэжлийн яам нь хяналттай оролцох хэрэгтэй байна. Уг нь хуулийн заалт нь байгаа. Тэгээд нөгөө зөвлөмж өгдөг бүх салбар дээр нэвтрүүлж байгаа цахим системүүдийг үр дүнтэй юм уу, хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу, үнэтэй юм уу, үгүй юм уу гэдэг дээр зөвлөмж өгөх асуудлыг Байнгын хорооноос тогтоол гаргаад явуулсан шүү дээ. Тэгээд тэр ямархуу түвшинд байгаа вэ? Ер нь цаашдаа иймэрхүү сайн төслөө алдах эсвэл дэмий юманд төсөв зарах эрсдэлийг бууруулах чиглэлээр ямар арга хэмжээ авч байгаа вэ гэдэг дээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас асууя. Дэлхийн банкны төсөвтэй холбогдуулаад, тэгээд цаашдаа ер нь яах вэ гэдэг дээр хариулт өгнө үү. Алтан-Од дарга.

П.Алтан-Од: Яг хэлэлцэж байгаа Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа асуудал дээр манай яам ажлын хэсэг бол биш л дээ. Тэгэхдээ байнга ЭМЯ-тай энэ цахим шилжилтийн асуудал дээр хамтарсан чиглэлээр ажлууд хийгдэж байгаа учраас, Дэлхийн банкны тэр тухайн асуудлууд дээр бид манай яам бодлогын хүрээнд эрүүл мэндийн цахим шилжилтийн асуудал дээр мэргэжилтнүүдээ томилж, энэ олон системүүдийг нэгтгэх, интеграци хийх, бас цаашид энэ зарим системийг нь цөөлөх, иргэд, үйлчлүүлэгчдэд ойлгомжтой болгох чиглэлийн ажлууд дээр нэлээн бодлогын хэмжээнд ажилладаг. Яг Дэлхийн банкны тэр тухайн төсөл дээр бид нараас тодорхой хэмжээний хариулт өгөх боломжгүй. Тэр хэрэгжүүлэгч байгууллага талаасаа мэдээлэл өгч явах нь зөв байх.

Ж.Золжаргал: Гишүүд асуулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байгаа болов уу? Үг хэлэх гишүүд байхгүй байна. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн талаар мэдээлэл өгсөн Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан болон ажлын хэсэгтээ баярлалаа.

17.38 цаг

Гурав.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

3 дахь хэлэлцэх асуудалдаа орёе. Хэлэлцэх асуудал 3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилт болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсоно. Мэдээлэл өгөхөөр, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой албан тушаалтнуудыг танилцуулъя. Түрүүн бид танилцуулчихсан шүү дээ. Сайдын мэдээллийг ТНБД Алтан-Од танилцуулна. Ороод ирлээ. Баатархүү сайд орж ирж байна. Энэ асуудалтай холбоотой санал бодлоо хэлэх зорилгоор салбарын төлөөллүүдийг урьсан байгаа. Төлөөлөл болгоод цөөн хэдэн хүмүүс эдгээр хүмүүсийг танилцуулъя. Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо Мита Чимэддорж, Монголын мэдээллийн бүгд ирсэн юм уу, технологийн тоног төхөөрөмж, шийдэл нийлүүлэгчдийн холбоо Эрдэнэбямба, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо Баттамир, Хэрэглэгчийн нийлүүлэгчдийн холбоо Баянмөнх, Цахим бүтээгдэхүүн хөгжүүлэгчдийн холбоо Батжаргал, Бизнес шинжээч төслийн удирдагчдын холбоо Агиймаа гэж хүмүүс хүрэлцэн ирсэн байна.

Хэлэлцэх асуудлын маань агуулга болохоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд 2021 онд зарим төрлийн мэдээллийг хувь хүний мэдээллийг нь нууж байгаад, тэгээд зах зээл, маркетинг, технологи хөгжүүлэгчдэд хэрэглэж болохуйц ийм нээлттэй болгож өгнө гэсэн агуулгатай заалт байдаг. Өнөөдөр 2025 он 4 жил хэрэгжээгүй явж байгаа. Тэгэхээр энийг яах юм бэ, яагаад энэ маань ингээд явж өгөхгүй байна вэ, хэзээ орох вэ гээд нэг асуулт. Нөгөөх нь болохоор Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн дагуу маш олон компаниуд start-up-ууд хиймэл оюун хөгжүүлж байгаа байгууллагууд дэмжлэг авах заалтууд байдаг. 2024 оны 6 дугаар сард батлагдсан хууль. Удахгүй нэг жил болох гэж байна. Хэрэгжилт байхгүй. Яагаад гэхээр журмууд нь гараагүй байгаа. Тэгэхээр энэ 2 асуудал дээр ямар асуудлууд тулгараад байгаа юм бэ, хэзээ хэрэгжүүлж эхлэх вэ? Ийм зорилготойгоор энэ мэдээлэл сонсох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Баатархүү танилцуулга хийнэ.

Ц.Баатархүү: Байнгын хорооны гишүүд болон өнөөдөр ингээд мэдээлэлд хүрэлцэн ирсэн хувийн хэвшлийн төлөөлөл, албаны бүх хүмүүст энэ өдрийн мэндийг дамжуулж байна. 2 чухал асуудлаар өнөөдөр нээлттэй сайхан ярилцъя гэдэг мэдээлэл бид өгөөд, болж байгаа асуудал юу юм, болохгүй байгаа асуудал юу юм бэ гэдгийг ярилцах нь зөв гэдэг байдлаар бид өнөөдөр Байнгын хорооны хуралд бэлдсэн байгаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар эхний танилцуулгыг хийх гэж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль батлагдсанаар 68 мэдээллийг мэдээлэл хариуцагч байгууллага зайлшгүй улирал тутамд цахим сүлжээ, цахим веб сайтаараа дамжуулж иргэдийн мэдээлэл авах, мэдээллийг хайх энэ эрхийг хангах зорилгоор цахим хуудаст байршуулах ийм хуультай. Энэ бүх үйл ажиллагаа маань өөрийн байгууллагууд өөрийнхөө цахим хуудаснууд дээр мэдээллээ байршуулдаг, нэмээд shilen.gov.mn дээр байршуулдаг. Ингээд 2 цахим хуудсанд мэдээллээ байршуулна. Тэгээд shilen.gov.mn дээр мэдээлэл байршуулж байгаа хэсгээр нь шилэн индекс өгөөд явдаг уламжлалт бидний байдал. Тэгээд ямар байгууллага нь цаг хугацаандаа мэдээллээ оруулдаг юм, оруулдаггүй юм бэ гэдгээ улирал болгоноор гаргадаг л даа. Гэхдээ энд сайжруулах зүйлүүд байгаад байгаа юм.

Ямар юм бэ гэхээр зөвхөн ингээд цаг хугацаандаа оруулдаг энэ мэдээлэл нь мэдээллээ оруулж байна гэдэг тэр 68 мэдээллийн агуулга, хэлбэрээр дүгнээд байдаг. Тухайн мэдээлэл нь үнэн зөв юм уу, баттай юм уу гэдэг дээр нь хяналт тавих гэхээр хяналт тавьдаг тийм институт байдаггүй. Бид бүхэн ингээд 5 мянга орчим мэдээлэл хариуцагч байгууллагыг ингээд мэдээллээ оруулаач гээд салбараараа хөдөлдөг нэг ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр одоо ямар хэлбэр лүү бид орох гэж байна вэ гэхээр ер нь энэ нийтийн мэдээллийн ил тод байдлын хүрээнд нийтдээ 22 захиргааны хэм хэмжээний акт гаргах ёстой. 17 актыг нь Монгол Улсын ЗГ болон Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд хамтарсан ийм сайдуудын тушаалаар гаргачихсан байгаа. 5 актыг гаргахаар ажиллаж байгаа, ажиллаж байна, бид ажиллаж байна. Тэгээд ямар асуудал энд тулгарч байна вэ гээд Золжаргал дарга маань хэлж байгаа. Энэний дараагийн слайд дээр байгаа. Одоо юу юм бэ гэхээр 4693 байгууллагын цахим хуудас байна салангид байна. Тэгээд энийг Монгол Улсын ЗГ тогтоолоор үүрэг өгөөд нэгтгэе.

Дэлхийн бүх хандлага төрийн байгууллагууд нь нийлээд нэг цахим хуудастай байдаг, нэг цонхоор иргэд мэдээлэл авдаг. Англи улсын жишээ байдаг, Эстони улсын жишээ байдаг. Тэгээд Монгол Улс ийм больё гээд gov.mn гэдэг рүүгээ нэгтгэж байгаа. Нэгтгэхэд мэдээж байгууллагууд маань өөрсдийнхөө мэдээллийг тийш нь оруулах, тэгээд тэр оруулсных нь дараа сургалт явуулах гээд тодорхой хугацаа шаардсан. Нэмээд мэдээлэл хариуцагч байгууллага маань shilen.gov.mn-д мэдээллээ оруулдаг. Энэ бүх ажил тухайн байгууллагын хувьд ингээд нөгөө механикаар буюу гар ажиллагаагаар оруулж байгаа учраас энд хүчээр шахуу зарим нь оруулдаг. Шилэн индекс гаргах гээд байна. Манай агентлагийн удирдлага энэ тэр ирчихсэн байна энэ ингээд л утасдана, албан тоот өгнө. Энэ маань эргээд нөгөө дижитал шилжилтийг хийхдээ бид ингээд нэлээн ийм гар ажиллагааны шахалтын маягаар, шаардлагын маягаар ингээд хийгээд байдаг. Энийг илүү яаж хялбар хийх вэ гэдэг рүүгээ бид танилцуулга хийх гэж байна.

58 байгууллага бид өгөгдөл буюу нээлттэй өгөгдлийг open data дээр оруулсан байгаа. Нийт 691 өгөгдлийг ЗГ-ын хурлаар нээлттэй энэ өгөгдлийг ашиглаж болно гэдэг шийдвэрийг гаргасан байдаг. Энд хурын систем ажиллаж байгаа. Хурын систем маань ИМонгол руу холбогдож төрийн үйлчилгээг өгдөг. Тэгэхээр одоо бид нарын гаргаж байгаа зураг бол ерөөсөө л энэ байгаа, гаргаж байгаа зураг бол ерөөсөө л энэ байгаа. Одоо бид нарын хийх гэж байгаа зүйл маань энд юу байна вэ гэхээр мэдээллийн сангууд нь байж байна. Мэдээллийн энэ сангуудаас нөгөө Золжаргал даргын хэлээд байгаа, бид нарын яриад байгаа тухайн хүний нөгөө хувийн шинжтэй зүйлүүдийг нь далдлаад, ингээд төрийн их өгөгдөл гэдэг рүү оруулаад, төрийн их өгөгдөл рүү оруулснаар төрийн их өгөгдлөөсөө бид gov.mn рүү орно, gov.mn рүү орсон тухайн байгууллагын мэдээллийг шууд автоматаар shilen.mn рүүгээ, shilen.gov.mn руугаа тавьчихна. Хүн ингээд түүнийг нь ингээд хуулаад л, линкээ тавиад л, линкээ тавьж уу гэдгийг нь дахиад хүн орж хянах биш шууд өөрөө энэний ард автомат хиймэл оюуны алгоритм ажиллаад gov.mn гэдэг нэгхэн энэ төрийн нэгдсэн цахим хуудас руу мэдээлэл хариуцагч байгууллагууд мэдээллээ өгөхөд бусад нь бүгд ингээд өөр өөрийнхөө байгууллагынхаа цонхнууд руу ордог болгоод энэ нь тэр shilen.gov.mn нь хугацаандаа орж байна уу гэдгийг нь мэргэжлийн холбоо юм уу, хувийн хэвшил байдаг юм уу хяналтаа тавиад явдаг ийм хэлбэр лүү оръё гэсэн ийм зургийг бид ЗГ-аар батлуулах гэж байгаа.

2 дахь зүйл нь энэ open data руу болохоор real time датанууд орох ёстой. Харамсалтай нь дахиад мэдээлэл хариуцагч байгууллага компьютерынхоо ард

сууж байгаад датагаа оруулдаг. Энэ open датагийн үндсэн философи өгөгдөл. Өгөгдөл гэдэг маань судлаачид, хувийн хэвшлийнхэн тухайн салбарын энэ бид нарын хэлдгээр raw датаг ингэж татаж аваад, судалгаа шинжилгээндээ ашиглаж болох энэ дата оруулах байтал ялгаагүй нэг ийм статистикийн мэдээ ордог. Тэгэхээр статистикийн мэдээ, өгөгдөл 2 өөр байдаг. Тэгэхээр шууд татаж аваад ингээд ашиглаад судалгаа шинжилгээндээ ашиглаж болох байнга орох ийм real time орох open дата ажиллаж эхлээгүй байгаа. Тэгэхээр энийг ажиллуулахын тулд бид ийм нэгдсэн холболт хийх энэ ажлыг эхлүүлээд энийгээ бид ЗГ-аар батлуулах энэ үйл явц явж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нэг зүйлийг ний нуугүй ярихад жишээ нь нээлттэй өгөгдлийн чиглэлээр opendata.gov.mn, shilen.gov.mn, opendata.burtgel.gov.mn, sudalгаа.gov.mn, 1212.gov.mn, 1313.gov.mn гэх юм уу энэ дижитал шилжилтийг хийх явцад байгууллага болгон ингээд ер нь ийм цахим системийг хөгжүүлж, дижитал шилжилтийг аль болохоор хурдан хийх гэсэн энэ оролдлогууд маань эргээд интеграци болдоггүй. Нэгдсэн нэг цонхоор мэдээлэл авах энэ боломжийг хязгаарлаад, бага зэргийн ийм замбараагүй байдлыг бий болгочихсон юм байна лээ. Тэгэхээр энэ болгонтой мэдээлэл хариуцагч байгууллагуудтай бид уулзаж ярилцаж, яг ийм зураг руугаа оръё гэдэг шийдлийг Байнгын хорооныхондоо танилцуулж байна. Тэгээд Байнгын хорооныхон маань энэ дээр ингээд асуулт асуугаад явахад бид хариулахад бэлэн байгаа юм.

Жишээ нь 2024 оны жилийн эцсийн шилэн индексийн үнэлгээ, үнэлгээний дундаж жишээ нь 1214 байгууллагаас үнэлгээний тайлангаа илгээсэн байна. Үнэлгээний дундаж нь 69 хувьтай гарсан байна л даа. Тэгээд энэ бүхний ард бид танайх хугацаандаа мэдээллээ оруулаач гэдэг. Зарим орон нутагт ажилладаг байгууллага энийг хугацаанд нь мэдээлэл оруулж байдаг тийм албан тушаал ч байхгүй, бид завгүй байдаг гэдэг ийм маягаар хүртэл хандаж байдаг. Тэгэхээр бид энэ байгууллагуудын индексийг гаргадаг. Тэгээд энэ индекс манай shilen.gov.mn дээр нээлттэй байдаг. Ямар байгууллага нь сайн оруулж байгаа юм, ямар байгууллага нь хугацаандаа оруулахгүй байгаа юм бэ гэж байгаа. Тэгэхээр энэ шилэн индекс маань хугацаандаа оруулж байгаа, тэгээд тэр 68 мэдээллийн иж бүрдлийг хангалттай оруулж байна уу гэдэг зүйлийг нь хэмжиж байгаа учраас яг иргэнд хэрэгтэй, үнэхээр хувийн хэвшилд хэрэгтэй, шаардлагатай энэ мэдээлэл байна уу гэдэг агуулгын чанар дээр нь одоогоор бид ингээд яг ингээд үнэлэлт дүгнэлт өгөх тийм цаг хугацааны боломж их бага байдаг юм байна лээ. Яагаад вэ гэхээр маш олон байгууллагын мэдээлэл орж байгаа учраас ийм байгаад байгаа юм гэдгийг та бүхэндээ хэлье. Тэгээд асуулт байвал хариулахад бэлэн байна, баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Нөгөө 2 дахь сэдэв маань энэ дээр асуултуудаа бүгдээрээ асуугаад, байр суурь сонсоно. 2 дахь нь болохоор Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль 24 оны 6 сард батлагдсан. Нөгөө дэмжүүлэх гэхээр татвараас хөнгөлөх, нийгмийн даатгалын шимтгэлээс хөнгөлөх энэ заалтууд нь журмууд нь гараагүй байна гээд ингээд байгаад байдаг. Тэгэхээр энэ асуудлууд ямар асуудал тулгараад ингээд байгаад байгаа вэ, хэзээ гарах гэж байна вэ? Энэ тал дээр мэдээлэл өгнө үү?

Ц.Баатархүү: 3 журам гаргахаар байгаа. Тэгээд журмуудыг нөгөө манай зөвлөл виртуал бүсийн зөвлөл ингээд батлаад явахаар байж байдаг. Тэгээд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль гараад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих энэ Гүржийн Казахстаны яг энэ виртуал зон болох энэ эхлэл тавигдсан хууль, эрх зүйн хувьд. Журам бид урьдчилсан байдлаар гаргасан. Тэгээд гол нь нөгөө нийгмийн даатгалын газар, Сангийн яам, татварын

газартай уулзахаар журмаар явахаар наад асуудал нэлээн тийм эрх зүйн хувьд бүрдэл хангахгүй байна гэдэг ийм асуудал тавиад, тэгээд олон дахин хуралдсаны эцэст бид энд та бүхэнд харагдаж байна уу, үгүй юу товчхон ингээд нэгхэн хуудсаар ингээд болохгүй байгаа асуудлаа бичсэн. Энийгээ ний нуугүй ярих нь зөв байх. Яагаад би энийг ярьж байна вэ гэхээр Байнгын хорооны хорооноос бид энэ дэмжлэг авах шаардлагатай байгаа Золжаргал даргаа. Улсын Их Хурлын гишүүдээс бид дэмжлэг авах шаардлагатай байгаа юм.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн тухай хууль дээр татварын болон татварын бус дэмжлэг үзүүлнэ гэдгийг заагаад өгсөн. Ямар эх үүсвэр байх вэ гэхээр улсын төсвийн эх үүсвэр байна. Нэмээд энэ салбарт ажиллаж байгаа кодыг гадаадад экспортолсон орлого, хандив, тусламж бусад гэдэг ийм эх үүсвэрийг заагаад өгсөн. Тэгээд улсын төсөвт төвлөрүүлж байгаа манай салбарынхны татварын орлого, торгууль ингээд бүгд нийлээд үзвэл 160 орчим тэрбум төгрөг байхаар байгаа юм урьдчилсан байдлаар. Энэний ингээд 40 орчим хувь гээд 8,5 тэрбум төгрөг ч юм уу ингээд байна гэж байгаа юм. 1 дүгээрт энийгээ ямар дансанд байршуулах вэ гэдгийг бид хууль дээр аягүй тодорхойгүй явчихсан байгаа. 2 дугаарт энэ эх үүсвэр дээр 3 янзын сангийн сангаас 5 хувийг нь авахаар байгаа. Гэтэл тэр нөгөө дагаж гарах нөгөө хууль чинь дагаж хуулиудын нэмэлт, өөрчлөлт ордог тэр нөгөө Сангийн хууль дээрээ энэнийхээ нэмэлт, өөрчлөлтийг хийж амжаагүй явчихсан юм байна лээ. Нэмэлт, өөрчлөлтийг. Тэгэхээр одоо бид нарт яг бодит ямар асуудал үүсэж байна вэ гэхээр 6 байх тийм ээ, би бас дутуу, буруу хэлж байж магадгүй шүү, манайхан нэмж хэлээрэй. 6 хууль дээр яаралтай нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байгаа нэмэлт, өөрчлөлт. Өгүүлбэрийн, 1 засварын.

Наад зах нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг энэ дэмжих бүсийн ажлын алба хаана байна вэ гэхээр яг хуулиараа IT паркийнхаа нэрийг бид буруу өгөөд хуулиар баталчихсан юм байна лээ. Одоо байгаа IT паркийнхаа нэрийг бид арай өөрөөр өгөөд баталчихсан. Энэ маань ажлын алба байна гэж байгаа юм. Нэмээд ажлын алба үүсгэнэ гэхээр ажлын албыг орон тоог нь бид зөвлөл дээр баталчхаж болж байгаа юм. Цалинг нь хэн өгөх вэ гэхээр дахиад аягүй тодорхойгүй байдал үүсэж байгаа. Энэ ч яах вэ ингээд ажлын албаны урамшуулал, орон тоо бол нэг их тийм энэ үйл ажиллагааг явуулахад том хүчин зүйл биш юм гээд үзэхэд тамга авахад дахиад нэрийн зөрөө үүсчхээд байгаа юм. Нэрийн зөрөө. Энэ ингээд санамсаргүй ийм зүйлүүд гарсан юм шиг байгаа юм.

Зээлийн батлан даалтын сан дээр бид нэмэлт, өөрчлөлт хийх шаардлага үүсэж байгаа, нэмэлт шаардлага үүсэж байгаа. Хамгийн сүүлд нь хүн, хуулийн этгээд гэдэг ойлголт, хүн, хуулийн этгээд дэмжлэг авна гэж оруулчхад яг виртуал zone дээрээ хуулийн этгээд гээд явчихсан. Тэгэхээр хуулийн логик маань эхний зорилго дээрээ хүн, хуулийн этгээд гэж явж байснаа виртуал бүсээс зөвхөн хуулийн этгээд гэдэг ийм өгүүлбэрээр явчихсан учраас цаашдаа бид хүн, хуулийн этгээд гэдэг логикоороо явах юм уу, хуулийн этгээд гэдгээрээ явах уу гэдэг асуудал үүсэж байгаа. Мэдээж энд манай хувийн хэвшлийнх ирсэн байгаа учраас мэдээллийн.../минут дуусав/

Ж.Золжаргал: Сайдын микрофоныг нэмж өгье.

Ц.Баатархүү: Жишээ нь мэдээллийн технологийн үйлдвэрлэгч гэдгээ яг хэн бэ энэ тэр гэдгийг энэ журмаар гаргаад ирж байгаа юм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэгч гэдгээ ямар хуулийн этгээд гэж үзэх вэ гэдгээ энэ журам энэ тэрээр тодорхойлж болж байгаа. Яг хөнгөлөлт авах үйл явц маань эрх зүйн бүрдэл

хангахгүй байгаа учраас бид 6 хууль дээр нэмэлт, өөрчлөлт бэлдээд, ингээд та бүхэнд танилцуулаад, Байнгын хорооны дэмжлэг авч байж Улсын Их Хуралд өргөн барих юм байна. Тэгэхгүй бол төсөв дээр бид эх үүсвэр дээрээ мөнгөө тавьж чадахгүй болчихоод байгаа юм. Журмыг хэчнээн ч сайн гаргаж болно. Гол асуудал бид нөгөө дэмжлэг үзүүлэхийн тулд эх үүсвэр. Тэгэхээр эх үүсвэрүүдийн хоорондын энэ зохицуулах эрх зүйн зохицуулалтыг тухайн үедээ бид гүйцэд арай харж амжаагүй байсан юм шиг байгаа юм л гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн. Энэ харагдахгүй байвал манайх ингээд тараагаад өгч болно шүү. Энэ нэлээн сайн судлаад яг энэ хуулийн энийг өөрчилье нэг ийм 6 асуудал байна гэдгээр нь оруулж ирж байгаа юм шүү. Ингээд нэмэлт зүйл байвал би.../минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа. 1 дүгээрт салбарын яамныханд хэлэхэд энэ Байнгын хорооны гишүүдэд танилцуулах материалаа жоохон эртхэн шиг тийм тэгээд долоо хоногийн өмнө нөгөө хугацаа товлож байгаа шүү дээ. Тийм түгээж байгаарай гэж хэлмээр байна. Тэгээд уншиж танилцах асуулт нь ч гэсэн оновчтой байх, цаг алдахгүй байх ач холбогдолтой. Гишүүд асуухаас өмнө энэ салбарын төлөөллөөс төлөөлөөд нэг цөөн хүний үгийг сонсох юм илүү тодорхой болох болов уу гэж бодож байна. Миний зүгээс энэ 2 сэдвийн хүрээнд эхнийх нь тэр нөгөө big data ашиглах, хиймэл оюун хөгжүүлэх гэхэд мэдээлэл өгөгдөл хэрэгтэй байгаад байдаг. Тэгээд тэрэндээ хүрч ашиглаж болдоггүй нэг ийм л асуудал байгаад байгаа. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт цахим индекс гэдэг бол бүх л утгаараа тийм ээ. Тэгэхээр тэр бүх л утгаараа хуулийн хэрэгжилт биш, яг энэ датаг авч ашиглах ямар боломж байна вэ гэдгийг бас ярилцъя гэж бодож байгаа. Зөвхөн яг ингээд бүх, ингэж ойлгож байна л даа төрийн их өгөгдөл үүсгэнэ. Үүний тулд ингээд мэдээллүүдийг хувиргаад, хувь хүний мэдээллийг нь нууж хувиргаад их өгөгдөл үүсгэнэ. Дараа нь gov.mn дээр ингэж бүгд нэгтгэгдэнэ. Тэгээд тэндээсээ Шилэн платформ руугаа яваад, тэндээс нь авч ашиглах гээд. Тэгэхээр энэ үе шат маань нэгтгэх процесс хугацаа их орох нь байна. Ингээд хүлээгээд байгаад байтал наана нь нөгөө ажил хийж байгаа хүмүүст өгөгдөл нь байхгүй байгаад байна. Тэгэхээр энэ дундаас чинь аваад загвар төслүүд хэрэгжүүлж болох юм уу? Хууль, эрх зүйн орчны ямар гаргалгаа байна. Бүх юмаа ингэж цэгцэлж хүлээхгүйгээр хувийн мэдээллийг нуусан байдлаар байгууллагууд дээр нь шийдвэрлээд явах арга зам байна уу? Тэгээд иймэрхүү сэдвээр бас асууя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарх сэдвийн хувьд ер нь энэ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль их яаралтай өнгөрсөн парламентын төгсгөлд гарч ирсэн хууль. Тэгэхээр их гоё ийм заалтуудтай, ингэж татвараас чөлөөлнө, тэгж НДШ-ээс чөлөөлнө гээд тийм grant олгоно гээд гаргачихсан. Тэгэхээр би саяын тайлбарыг хараад бас үндэслэлтэй юм байна даа гэж одоо ойлгож байна л даа. Энэ чинь яарч гаргасан учраас бусад хуулиуд дээрээ ямар заалт өөрчлөлтүүд байх байсан шаардлагатай байсан байна гээд. Тэгэхээр энэ маань бараг нэлээн удаан хугацааны дараа ийм дүгнэлтэд хүрч ирж байна шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бодвол журам дээр ажиллаад, тэгээд болохгүй болохоор ингээд яамд хоорондоо ярилцсаар байгаад л ер нь хуулиуд дээрээ ингээд дагасан хуулиуд дээр өөрчлөлт орох ёстой юм байна гэдэг дүгнэлт гарч ирж байгаа юм байна. Ингээд үргэлжлээд бид яваад байвал нөгөө муу компаниуд маань ингээд л хараад л байдаг, хараад л байдаг. Узбекстанд тэгдэг, Казакстанд ингэдэг гээд.

Тэгээд бид ингээд журам гарах гэсэн чинь төвөгтэй болоод хууль руугаа орлоо. Тэгэхээр хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг л яам маань маш хурдан хугацаанд саналаа боловсруулж орж ирээд ингээд Их Хурал дээр бид Байнгын хороогоороо

хэлэлцээд авч явах юм байна гэсэн ийм ойлголт авч байна. Ингээд асуулт асуухаас өмнө ерөнхий агуулга ийм байсан гэж сая тодруулчихлаа. Асуулт асуухаас өмнө энэ салбарын байгууллагуудаас 3 хүн төлөөлөөд 4 минутад багтаагаад байр сууриа илэрхийлнэ үү гэж хүссэн юм. Тэгээд асуулт асуухгүй, та бүхэн шууд байр сууриа, санал байвал хэлээд явчхаарай. Гараа өргөөд, хэдэн номер дээр яах вэ, тэнд 3 номер дээр очоод, 3 номерын микрофон дээр очоод ярьчихъя. Тэгээд санал хэлэх хүмүүс маань өөрийгөө танилцуулаад, байгууллагаа танилцуулаад тэгээд саналаа хэлнэ.

А.Баттамир: Баярлалаа. Программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч Баттамир, ICT групп компанийн бас үүсгэн байгуулагч байгаа юм. Юуны хувьд яах вэ яг энэ асуудалтай холбоотойгоор үндсэндээ яг 2 чухал асуудал холбогдож байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай холбогдуулаад хэлэхэд, тийм энийг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай холбогдуулаад хэлэхэд яах вэ энэ хууль маань ингээд маш үр дүнтэй чухал хууль байгаа юм. Тэгээд энэ хуулийнхаа хүрээнд саяын энэ 152 төрөлжсөн мэдээллийн сан гээд ярьж байна. Тэгэхдээ төрөлжсөн мэдээллийн сан дотор нь яг ямар жагсаалт байгаа нь одоохондоо зүгээр мэдэхгүй байна. Тэгээд бодвол нэг жагсаалт баталчихсан юм уу эсвэл байгаа юм уу нэг тийм юм байгаа байх.

Тэгэхээр энэ дотроо бүүр ингээд priority тавьж тавьж байгаад хамгийн түрүүнд эдийн засагт хамгийн impact үзүүлэхээр нэг салбарыг нь шууд сонгоод мэдээллийн санг нь сонгоод авчихмаар байгаа юм. Тухайлбал манай энэ салбарынхан байнга ярьдаг. И баримтын мэдээллийг жишээлбэл open data болгоё нээлттэй. Энийг бас нэлээн хэдэн жилийн өмнөөс ярьж л байсан юм. Тэгэхээр нөгөө нэг ойлголтын асуудлууд гарч ирээд байдаг. Одоо open data гээд тэгэхээр Баттамир юу худалдаж авах гээд байгааг ил болгох гээд байгаа юм уу гээд нөгөө бүртгэл gov.mn дээр байдаг шиг ийм ойлгоод байдаг. Тэгтэл үгүй ээ бид нарын хүсээд байгаа юм чинь ийм биш шүү дээ. Open data дээр байх шаардлага буюу 1 дүгээрт announce хийгээд хэн бэ гэдэг хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг нь дарна, хоёрдугаарх нь лицензэд болгоё. Тэгэхээр өөрөөр хэлбэл энийг ашиглаад хийж байгаа судлаачид нь судалгааны арга зүй ethics хувьд асуудалгүй гэдэг боломжийг нь бүрдүүлье. Гуравдугаарх нь машин ... болгоод өгье. Тэгэхээр өөрөөр хэлбэл одоо нөгөө шилэн жишээлбэл gov.mn ч юм уу энэ мэдээлэл зарим юман дээр ингээд харахаар PDF-р мэдээллүүд тавьчихсан шууд авах боломжгүй байдаг. Тэрэнд чинь өөрөө json ч юм уу нэг тийм машин уншигдах хэлбэрээр байх ёстой. Тэгэхээр энэ мэдээллийг нь хамгийн түрүүнд бүүр priority тавьж байгаад эхлээд И баримтыг, тэгээд нөгөө нийгмийн даатгалын мэдээллийг хийдэг иймэрхүү сангуудыг гаргаад өгье. Бусад орнууд энийг чинь аль 10, 20 жилийн өмнөөс ингээд хийчихсэн. Тэгээд энэ дээр суурилсан маш олон шинэ бизнесүүд бий болох, том болон жижиг, дунд бүх бизнесүүдэд маш их дэмжлэг болно. Тэгэхээр энийг нь энэ журмыгаа хүлээлгүйгээр эсвэл нэг тийм ... төсөл хэрэгжүүлдэг юм уу ийм байдлаар та бүхэнд дэмжиж өгөөч. Би сүүлд нэг сонсоход бараг тэрбум гаруй бичлэгтэй нэг том, том өгөгдлийн сангууд л үүсэж байгаа гээд тэгсэн. Тэгсэн нөгөө өөрөө хэрэглэхгүй, тэгээд хүнд хэрэглүүлэхгүй ингээд хадгалаад баймааргүй байна.

2 дугаар асуудлын хувьд би өөрөө нөгөө ажлын хэсэгт нь байж байгаа болохоор мэдээллийн хувьд байгаа. Тэгэхдээ би нөгөө нэг татвар хөнгөлөлт эдлэх журам батлах тэрний ажлын хэсэгт байгаа. Түүн дээр бас яг энэ асуудлууд үүсэж байна лээ. Тэгэхээр энэ асуудлуудыг нь мөн яаралтай шийдэх шаардлагатай байх. Тэрнээс гадна яах вэ нэгэнт хууль хэрэгжсэн юм чинь журмыг нь дахиад ойрхон, ойрхон баталж болох юм чинь энэ хуульд өөрчлөлт оруулалгүйгээр хийж, хийх

боломжтой тэр журмуудыг нь эхний хувилбараар гэх юм уу хаашаа юм. Тэгээд энийгээ яаралтай нэг баталж тавьчихаад, тэгээд хууль нь батлагдахад ч цаг хугацаа орох л байлгүй дээ. Тэгээд тэр үед нь дараагийнхаа журмынхаа шинэчлэлийг хийгээд явчихвал болдоггүй юм уу гэдэг ийм 2 санал байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Өөр санал хэлэх хүн байгаа юм уу, байна уу, болсон уу? Өөр санал хэлэх хүн байна уу? Байвал гараа өргөөд, та 3 номерын микрофон дээр очоод хэлээрэй.

Ч.Агиймаа: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Намайг Агиймаа гэдэг би өнөөдөр бол Бизнес шинжээчид төслийн удирдлагын холбоог төлөөлж ирсэн байж байгаа. IT ... компанийн захирал. Энэ эхний 1 дүгээр асуудал дээр яг нөгөө өгөгдөл нийтийн мэдээллийн дэд бүтцийн нэгдсэн төлөвлөлт opendata.gov-г яг нэгдсэн цэгцтэй болгомоор байна. Нийтдээ энэ 576 байгууллагын мэдээллийг бүгдийг нь нэгдсэн байдлаар нөгөө big data үүсгэх энэ тухай. Энэ дээр бидний хувьд ингээд харахаар яг нөгөө бизнес шинжилгээ хийж байна, буцаагаад эргүүлээд эндээсээ мэдээллээ гаргаж авч байна гэдэг дээр хамгийн гол юм мэдээллийн ангиллыг нэлээн сайн журамлаж өгөх хэрэгтэй байгаа.

2 дугаарт нь өгөгдлийн стандарт гэдэг ийм юмыг яг журмаараа аягүй сайн баталж, яг нөгөө мэдээллээ анхнаасаа яг ямар байдлаар цэгцтэй оруулах вэ гэдэг дээр яг журмын заалтууд руугаа нэлээн оруулах нь зүйтэй гэж хараад байгаа юм. Мөн яг нэг дор хэрэгжүүлэх бол нэлээн урт хугацааны ажил болох учраас энийг хэсэгчилсэн буюу нөгөө файлот байдлаар хэсэгчилж ингэж хэрэгжүүлэх нь нэлээн үр дүнтэй болов уу гэж хараад байгаа юм. Өөр тайлбар, нэмэлт тайлбар байхгүй.

Ж.Золжаргал: Баярлалаа, болсон уу? Баярлалаа, санал хэлсэн хүмүүст баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхбат гишүүн, Пунсалмаа гишүүн, Золжаргал асуулт асууна. Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгье.

Ц.Мөнхбат: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Манай Цахим яам сая манай Байнгын хорооны дарга хэлчихлээ. Материалууд арай жоохон түрүүлж ирмээр байна. Сая гуйж байж тэр сайдын презентацийг бид авч энэ дэлгэц дээр үзэж байна шүү дээ. Эндээс харахаар харагдах ч үгүй юм 1 дүгээрт.

2 дугаарт жоохон смартлаг баймаар байна хэдүүлээ. Манайх чинь IT-ийн яам шүү дээ, IT-ийн салбар. Мэдээлэл технологийн шинэ энэ дэвшилтэт янз янзын арга хэлбэрүүдийг одоогоос үйл ажиллагаандаа нэвтрүүлэх мөрдөхөд бид манлайлах ёстой шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ тал дээрээ бас анхаармаар байна гэж хэлмээр байна.

3 дугаарт энэ нийтийн мэдээллийг биш ээ, тэр нөгөө юу их чухал. Тэр олон системүүд тус тусдаа системүүд байгааг нэг систем болгох гэж байгаа гээд ингээд ярьж байна. Тэр мэдээж их чухал. Энгийн иргэд битгий хэл мэргэжлийн гэж хэлж болох энэ салбарт ажиллаж байгаа гэж байгаа хүмүүсийн заримыг нь ялгаж салгахтайгаа байдаг л ийм олон системүүд байгаад байгаа шүү дээ манай энэ салбар дээр. Тэгэхээр зэрэг энийгээ нэгдсэн болгоно гэдэг маш чухал асуудал гэж ингэж бодогдож байна. Тэгээд энэ сая 6 хуулийн нэмэлт, өөрчлөлт орох гэж байгаа. Зарим нэг сангуудын журам ойлгомжгүй байгаа. Хэдүүлээ нөгөө төсөв баталж байхад л ярьж байсан шүү дээ энэ асуудал. Тэгээд энэ ингээд 4 сар гаруй болчихлоо төсөв баталснаас хойш энэ хугацаанд оруулаад ирье гэхээр яг юу нь болохгүй

байгаа юм бэ, хаанаа ямар учир шалтгаан байгаа юм бэ гэдгийг асуумаар байх юм. Байнгын хороонд оруулаад ирвэл Байнгын хороо эндээс нэг их эсэргүүцээд юм уу юу яах тийм юм байхгүй байх гэж бодож байна. Тэгээд Байнгын хорооноос дэмжлэг авмаар байна гээд сая хэлэх шиг боллоо сайд. Тэгэхээр энэ дээр жишээ нь ямар асуудал байдаг юм бэ гэдгийг 1 дүгээрт тодруулмаар байна.

Манай Тамираа манай Программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо мэдээж энэ журам юмыг хүлээлгүйгээр явж болдоггүй юм уу гэсэн утгатай юм ярилаа. Энэ дээр жишээ нь сайд ямар бодолтой байгаа юм бэ, сайд тушаал гаргаад шийдэж болдог юм уу энийг эсвэл заавал хуулийг нь тодорхой болгож Их Хурлаар тогтоол гаргуулж байж явдаг эд үү гэж бас асуумаар байна.

3 дугаарт нь манай энэ мэргэжлийн холбоонуудын удирдлагууд өнөөдөр энэ хуралдаанд оролцож байна л даа. Энэ хүмүүс маань тэгээд сая бараг давхацсан маягтай 2 төлөөлөл үг хэлэхдээ давхацсан маягтай тийм үг хэлчихлээ. Ер нь өнөөдрийн энэ хуралдаанд ямар үүрэгтэй оролцож байгаа юм бэ? Адилхан яамнаасаа мэдээлэл авч байгаа юм уу эсвэл өөрсдийн.../минут дуусав/

Ж.Золжаргал: Мөнхбат гишүүний микрофоныг 1 минут нэмье.

Ц.Мөнхбат: Өөрсдийн холбоонд байдаг гишүүн байгууллагуудынхаа эрх ашгийг хамгаалах гэж юм уу, тэдний дуу хоолой болж оролцох ёстой юм уу? Хэрвээ өнөөдөр яамнаасаа мэдээлэл хамтдаа бид нартай адилхан авах гэж энд оролцож байгаа бол яагаад манай яам мэргэжлийн холбоонуудын уялдаа холбоо ийм муу байгаа юм бэ гэж асуумаар санагдах юм. Энэ дээр нэг хариулт өгөөч гэж.

Ж.Золжаргал: Сүүлийн асуулт дээр нь хэлэхэд би энэ Байнгын хорооны хурал даргалагчийн хувиар салбарын төлөөллүүд компани юм уу, мэргэжлийн холбоод хамаагүй энэ дээр байр сууриа хэлээсэй гэсэн үүднээс урьж оролцуулж байгаа юм шүү. Тэгээд Баатархүү сайд асуултад хариулъя.

Ц.Баатархүү: Тавьж байгаа ажил хэрэгч шүүмжийг хүлээж авч байна. Дараагийн хурал дээр долоо хоногийн өмнө материал танилцуулга юмаа өгчихье. Түүн дээр бас хүлцэл өчье, манайхан бас анхаараарай. Ер нь Их Хурал энэ юун дээр энэ Их Хурлын гишүүдэд танилцуулгыг урьдчилж өгөхгүйгээс болоод хууль ингээд чанаргүй гараад байгаа. Монгол Улсад 830 хууль байна. Тэгээд маш олон удаа нэмэлт, өөрчлөлт ордог, аягүй хурдан баталчихдаг. Би бас Их Хурлын гишүүний хувьд энэнд их санаа зовж байгаа. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн тухай хууль маш зөв хууль. Бид арай яаран бас зарим нэг зүйлийг арай анзааралгүй баталсан юм байна лээ. Энэ манай энэ холбооны төлөөллүүд дээр ажлын хэсэгт бүгд байгаа. Ер нь манай энэ мэдээллийн технологи, цахим хөгжил, инновацын салбар ингээд бүх төлөөллүүдээ хангаад ажлын хэсэгт оруулчихдаг юм. Оруулаад явж байгаа Мөнхбат гишүүнд хэлэхэд. Баттамир холбооны ерөнхийлөгч ажлын хэсэгт байж байгаа.

Бид яагаад удсан бэ гэхээр нэгэнт 26 оны улсын төсөвт энийгээ л эх үүсвэрээ суулгая гэдэг байдлаар Сангийн яамтай яриад, тэгээд 25 онд яагаад суулгаагүй вэ гэхээр ингээд хууль дөнгөж гараад, тэгээд 25 оны төсвийг Их Хурал байгуулагдаж байхад ер нь боочихсон байсан. Тэгээд бид энэ журам энэ тэрээ гаргаагүй, Сангийн яамтай ойлголцоогүй. Манай хуулийг энэ тусгай сангийнхан, нийгмийн даатгалынхан, татварынхан бүрэн ойлголт аваагүй байсан. Ингээд тал бүрээс ажлын хэсэг байгуулаад, журмаа гаргаад явчихна гэсэн чинь нөгөө дагаж оруулах

хуулиуд дээрээ нэмэлт, өөрчлөлт ороогүй байна гэдэг хамгийн сүүлийн дүгнэлтүүдэд хүрсэн учраас бид эргээд нөгөө Сангийн яам, гол бусад нөгөө эх үүсвэр тавих газартайгаа л ойлголцохгүй бол энд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаал гараад, нөгөө дэмжлэг үзүүлэх эх үүсвэр нь бүрдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Хаанаа ямар дансанд ч байршуулах нь тодорхойгүй, хэн энэ данс байлаа гэхэд энд мөнгө төвлөрүүлэх нь тодорхойгүй, тэр нь улсын төсөв дээр суугаагүй учраас нэг зүйлийг хэлэхэд 26 оны төсөв дээр энийг суулгах нь гарцаагүй бид нарын үүрэг. 25 ондоо 26 онд суухад ямар ч маргаангүй эрх зүйн хувьд хоорондоо зөрчилгүй нэгмөсөн ийм сайн хуулийн нэмэлт журамтай болъё гэдэг байдлаар л бид ажиллаж байгаа.

Тэгэхгүй бол яараад нэг юм батлуулчихдаг ЗГ-аар. Тэгээд Хууль зүйн яам тэрийг нь бүртгэх дургүй болчихсон. Хууль зүйн яам чинь яагаад байна вэ гэхээр хуулиас давсан журам бүртгэхгүй гэдэг байдлаар явдаг. Тэгээд бид ингээд 3 журмын төсөл энд байж байна л даа. Бие биеийгээ ингээд нэг ажил хийж байгаа юм шиг цаасаар юм уу, журмаар аль болохоор ингээд тоогоор битгий ингэж ажлын гүйцэтгэл хангаач гэдэг байдлаар бид яаман дээрээ чиглэл өгөөд, 26 онд л Сангийн яамтай ойлголцсон, 26 оны төсөв дээр л яг тодорхой хууль, эрх зүйн хувьд бэлэн байдлаар энийг шийдье гэсэн ийм байдлаар ажиллаж байгаа шүү. Дутуу зүйл байвал би бас нэмэхэд бэлэн. Ийм л хариулт өгье дөө.

Ж.Золжаргал: Гишүүн болсон уу? Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Оройн мэнд. Shilen.gov.mn гэдэг энэ хаяг дээрээ бүх төрийн мэдээллийг нэгтгэе гэдэг нь энэ их зөв санал орж ирж байна. Тэгээд 4600 орчим байгууллагуудын мэдээллүүдийг нэгтгэж чадаагүй, интеграци хийх шаардлагатай гэж үзэж байна. Энэ ингээд 4600 орчим байгууллагуудын мэдээллийг интеграци хийхэд ер нь хэдий хэр хэмжээний хугацаа зарцуулагдах юм бэ? Огт ер нь интеграцилагдахгүй ийм байгууллагын мэдээллүүд гэж байна уу 1 дүгээрт.

Хоёрдугаарх нь болохлоор иргэдээс ер нь маш их хэмжээний саналууд ирж байдаг, саналууд ирнэ, хүсэлтүүд ирнэ. Төрийн байгууллагууд руу. Энийг ер нь түрүүлээд энэ олон 5 мянга орчим байгууллагуудын мэдээллийг нэгтгэхээсээ өмнө бүх төрийн байгууллагуудад ирж байгаа энэ иргэдээс ирж байгаа санал хүсэлтүүдийг түрүүлээд нэг цонхон дээр хүлээж аваад буцаагаад энэ 5 мянга орчим байгууллагууд руугаа тарааж явуулах ийм түрүүлж авах арга хэмжээг хэрэгжүүлж болох уу гэдэг ийм 2 дахь асуултыг асууя.

Ж.Золжаргал: Батбаатар дарга Төрийн цахим үйлчилгээний газар 3 номерын микрофон нээж өгнө үү.

П.Батбаатар: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга Батбаатар. Монгол Улсын ЗГ-аас 5Ш ажиллагааг 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр ЗГ-ын 49 дүгээр тогтоолоор зарласан байдаг. Энэ хүрээнд 5Ш ажиллагааны нэг ажиллагаа болох шил ажиллагааны хүрээнд Shilen.gov.mn цахим системийг ашиглалтад оруулаад ажиллаж байгаа. Энэ хугацаанд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 1 0, 2 0 гэсэн хувилбарыг гарган ажиллаж байгаа. Үүн дээр өнөөдрийн байдлаар УБЕГ-аас авсан мэдээллээр 5600 байгууллага энд мэдээллээ ил тод болох ёстой байгаа. Үүнээс яг өнөөдрийн байдлаар 3310 байгууллага бүртгэлээ хийгээд, мэдээллээ ил тод болгож байгаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2021 оны 12 сард батлагдаад, 2022 оны 5 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Үүнээс хойш мэдээллийг ил тод болгох асуудлыг ярьж байгаа. Үндсэндээ энэ хуулиар мэдээлэл хариуцагч байгууллагууд буюу төрийн бүх байгууллагууд байнга мэдээллээ ил тод болгох үүргийг хүлээсэн байдаг. Үндсэндээ тухайн байгууллагууд хуулиа өөрсдөө хэрэгжүүлээд ажиллах ёстой гэсэн ийм асуудал байгаа. Тэгэхээр бид сая нэлээн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамтайгаа хамтраад холбогдох 5600 байгууллагууд руу албан бичиг, сургалтыг хийгээд өнөөдрийн байдлаар он гарснаас хойш 200 гаруй байгууллагыг мэдээллийг нь ил тод болгох ажлыг хийгээд явж байгаа. 2500 орчим төрийн албан хаагчдад мэдээллээ ил тод сургалтыг давхар хийгээд явж байгаа.

Үндсэндээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үндсэн 2 хэсэгт байгаа. 1 дүгээрт мэдээллийг ил тод болгох, 2 дугаарт саяын нээлттэй өгөгдлийн асуудлын талаар байдаг. Сая харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн холбогдох оролцож байгаа холбооноос оролцож байгаа гишүүд асуулт асууж байна. Энэ асуулт дээр бас нэмээд хариулья. Энэ дээр үндсэндээ саяын өгөгдөлтэй холбоотой аргачлалыг энэ стандартыг энэ дээр тогтоож өгсөн байгаа холбогдох ЗГ-ын журмууд буюу Нээлттэй мэдээллийг ил тод байлгах шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээ хийх журам. Энэнээс гадна Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдлийг бий болгож, нийтлэг ашиглах нөхцөл журмыг, Нээлттэй өгөгдөлд тавигдах шаардлага болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем, үйл ажиллагааны журам, Нээлттэй өгөгдлийн жагсаалт, нээлттэй өгөгдлийг нийтлэх журам, ингээд Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөх, зардал тооцох, аргачлах, журам гэх мэт ингээд 3, 4 журмыг баталчихсан байгаа. Тэгэхээр холбогдогч талууд маань энэ журмыг сайн олж хараад, түрүүний Баттамир захирлын хэлсэн json, csv, xml гэх мэт өргөтгөлөөр оруулахаар оруулсан байгаа. Сая сайд бас хэлсэн. 60 гаруй байгууллагын 691 өгөгдлийг нээлттэй ил тод болгох, өгөгдлийн саяын машинд уншигдахуйц хэлбэрээр байршуулах энэ асуудлыг бас энэ журмаар тогтоосон байдаг юм шүү. Тэгэхээр энийг та бүхэн маань уншаад яах вэ f... маягаар ашиглаад энийг нэг салбараар нэлээн шахаж үзэх нь зөв гэж үзэж байна. Баярлалаа асуултад хариулт дууслаа.

Ж.Золжаргал: 3 номерын микрофон.

Б.Бат-Өлзий: Сайн байна уу, сайн байцгаана уу? Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим бодлогын төлөвлөлтийн газрын дарга Бат-Өлзий байна. Пунсалмаа гишүүний асуусан интеграцийн яг асуудал хамгийн түрүүнд аягүй чухал асуудал байгаа. Энэ асуудал дээр бид яг би зургаа харуулж байгаад яривал их зүгээр байгаа. Энэ мэдээж энэ бол их тийм ерөнхий ойлгомжтой байлгах үүднээс товчилсон зураглал байгаа. Энэний хүрээнд маш олон техникийн технологийн шинжтэй олон төрлийн ажлууд хийгдэнэ. Энэ дээр хамгийн түрүүнд gov.mn дээр нэгтгэх ажил өнгөрсөн жилээс хийгдчихсэн. Бүгдэд нь төрийн бүх байгууллагуудад эрхийг нь үүсгэчихсэн, төрийн байгууллагууд өөрсдийнхөө мэдээллийг оруулаад явж байгаа. Энэ ажлыг ер нь эрчимжүүлэх зорилгоор тодорхой хугацаа заагаад 6 сар юм уу, хагас жилээр.../минут дуусав/

Ж.Золжаргал: 3 номерын микрофон нээж өгнө үү.

Б.Бат-Өлзий: Төрийн бусад бүх домэйн хаягуудыг нь хаах гэж байгаа юм. Ингээд хааж өөрсдийнх нь зөвхөн энэ нэг цэгээр нэг цонхноос мэдээллийг авахыг нь нээнэ гэдэг энэ нэг ийм ажил байгаа. Энэ бол хагас жилийн дотор хийгдэнэ. Тэр

Shilen.gov дээр нөгөө автоматаар бүх мэдээллийг нь авдаг болгохын тулд энэ дээр хөгжүүлэлт хийх хэрэгтэй байгаа. Тэгэхээр бид нарын тооцоогоор энэ оны 3 дугаар улиралдаа багтаагаад хийж дуусгана гэж тооцоолж байгаа. Энэ дээр яалт ч үгүй нөгөө хөгжүүлэлт хийгдээд, gov.mn-ээсээ бүх мэдээллийг нь автоматаар татдаг байх юм. Тэгээд түүн дээрээ дүн шинжилгээ хийгээд энэ, энэ байгууллага нь оруулсан, оруулаагүй мэдээллээ нээлттэй тавьж байна, өөрчлөхгүй байна, өөрчлөөд байна гэдгийг нь дүгнээд гаргаад ирдэг болж байгаа юм. Тийм байгаа юм. Баярлалаа.

Ж.Золжаргал: Пунсалмаа гишүүн нэмэлт тодруулга.

Б.Пунсалмаа: Иргэдээс ирж байгаа саналыг нэгтгээд, тэгээд энэ байгууллагууд руу буцаагаад явуулах энэ ажлыг түрүүлээд хийж болох уу гэж асуусан.

Ж.Золжаргал: 3 дугаар микрофон.

Б.Бат-Өлзий: Санал гомдлын шугам бол хэд хэдэн шугамаар авч байгаа. Яг 11 11-ээр ер нь бас ЗГ-ын сүүлийн үүрэг чиглэлээр бүх иргэдээс ирж байгаа санал гомдлыг цахимаар, утсаар, цаасаар бүх төрлийн гомдол, санал гомдлыг ер нь 11 11 төвөөрөө дамжуулж авна. 11 11 төв маань өөрөө олон төрлийн сувагтай болох ийм ажлууд хийгдээд явж байгаа. Одоогийн байдлаар gov.mn дээр шууд иргэнээс энэ тухайн байгууллагыг ямар нэгэн гомдол санал гомдлыг веб дээр нь санал гомдлын товч нээчихсэн байгаа. Тэрнийхээ дагуу шууд гомдлоо өгч байгаа. Ялангуяа дээд байгууллагад нь гомдол мэдүүлэх боломжтой.

Ж.Золжаргал: Би нэмээд түрүүний асуултыг дахиад тодруулаад асуучихъя. Энэ бүх мэдээллээ нэгтгэж 3 дугаар улиралд, тэгээд магадгүй нөгөөх нь жигдрэх гээд дахиад үргэлжилж болзошгүй. Тийм болохоор Файлет төсөл түрүүн И баримтын мэдээллийг жишээ нь ашиглая гэж байна шүү дээ. Иймэрхүү байдлаар сонгож аваад, Файлет төслийг яаралтай гаргаад тэр датануудыг ашиглах энэ боломжийг аль төрлийн мэдээллийг хэзээ гаргах боломжтой гэж бодож байна вэ? Энэ талаар санал бодлоо хуваалцана уу? 3.

Б.Бат-Өлзий: Түрүүнд нээлттэй болгох интеграцийн талын асуудал байсан. Одоо яг энэ дээр энэ их өгөгдөл үүсгэх гэж байгаа энэ процессыг өнгөрсөн жилийн сүүлээс эхлээд манай яам Дата төв, ИМонгол академитай хамтраад хүн, хуулийн этгээдийг таних боломжгүй болгох аргачлалаа гаргаад туршчихсан. Турших процессын үед бид статистикийн дата дээр хүн, хуулийн этгээдийг танихгүй болгоод гаргаад туршиж үзээд амжилттай болчихлоо гэж үзээд хамгийн түрүүнд Нийгмийн даатгалын ерөнхий газар бол датагаа өгье гэж зөвшөөрсөн. Эхлээд туршъя, хамт хамтаръя гэсэн. Дараагийн ээлжид Эрүүл мэндийн сая өнөөдөр бас танилцуулга дээр ярьж байгаа ЭМД-ын системийн дата бол эрүүл мэндэд хамгийн том дата байгаа. Энэ датаг бас авч туршихаар ингэж ажиллаж байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

Ж.Золжаргал: 3 номер нэмэлт цаг, хэзээ?

Б.Бат-Өлзий: Энэ 152-ыг нэгтгэх гэж энэ удаан хугацаа явагдана. Харин бид 6 сард юу танилцуулах гээд байгаа юм бэ гэхээр хагас жилээр эхний 2 датаг холбож үзүүлэх гээд байгаа юм. Тэгээд 1 дата нийт нэгдсэн их өгөгдлийг эхний байдлаар үүсгэчихлээ гэдгийгээ зарлаад бусад төрийн байгууллагуудаа бага багаар оруулна.

Яагаад гэхээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиараа өөрөө мэдээлэл үүсгэгч эзэмшигч нь энэ мэдээллийнхээ аюулгүй байдлыг хангадаг учраас энэ мэдээлэл дээр бид өгөгдлийн санд өөр байгууллага орох боломжгүй, манай байгууллага хүртэл орох боломжгүй. Энэ өөрөө нууцын мэдээллүүд байдаг учраас тухайн байгууллага нь өөрөө энийг таних боломжгүй болгох процессыг хийгээд манайх руу холбоно уу гэсэн үг. Энэ аргачлал систем script-ийг нь кодыг нь биччихсэн гэсэн үг. Тэгээд эндээс холбоод явах, бага багаар холбоод явна гэсэн үг. Тэгэхээр энэ 152 өгөгдлийн сантай байгууллагууд маань.../минут дуусав/

Ж.Золжаргал: Тэгье, үг хэлэхэд асуух юм уу та? Тэгье. Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүн нэрээ өгнө үү? Мөнхбат гишүүний микрофоныг нээж өгье.

Ц.Мөнхбат: Би түрүүн нэг юм мартаад яачхаж. Энэ сая энэ их өгөгдөл ярьж байна. Манай аймгууд ч юм уу, нийслэл дээр камержуулалтын асуудал нэлээн идэвхтэй яриад байгаа шүү дээ. Аюулгүй байдалтай холбоотой. Тэгээд энэ Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газраас тэр камержуулалтыг хийхдээ царай таньдаг программ хангамж бүхий камержуулалт байх ёстой гэсэн нэг ийм шаардлага тавиад байдаг юм байна лээ. Тэгэхээр 1 дүгээрт тэр нь төсөв нэлээн өндөр болчихдог. 2 дугаарт нөгөө талаасаа манай энэ дата өгөгдлийн энэ том тийм боломж нь байдаг юм уу, царай таних программ уншдаг тийм юу хийснээрээ манайд тийм хэмжээний дата байдаг юм уу? Хүн болгоны тэр царай дүрсийг нь оруулчихсан ийм юм байдаг уу? Одоо бид нарын энэ ярьж байгаа үүсгэж байгаа энэ big дата дотор? Энийг би нэг тийм танин мэдэхүйн чанартай 1 дүгээрт асуучихъя гэж бодож байна.

2 дугаарт нөгөө түрүүн Баатархүү сайд та журмын өөрчлөлтийг оруулах гээд байгаа шүү дээ ирэх оны төсөв батлагдахаас өмнө энэ ондоо багтааж хэдүүлээ шийдэх ёстой гээд түрүүн ярилаа. Яг хэзээ орж ирэх юм бэ? 6 сараас бараг нөгөө төсвийн урьдчилсан төсөөллүүд чинь яамнууд руу, үгүй ээ Сангийн яам руу явдаг байлгүй дээ. Тэгэхээр тэр яг хэзээ орж ирэх юм бэ гэж? Ийм 2 зүйл дээр.

Ж.Золжаргал: 3 дугаар микрофон.

Б.Бат-Өлзий: Царай таних технологийн хувьд бид нэгдсэн байдлаар иргэний хувь хүний тэр мэдээллийг шууд камертай холбох гэдэг одоогийн хуулиар ер нь асар хэцүү. Энэ царай таних юун дээр бол яг одоогийн шууд иргэний хувийн мэдээллийг тэр бусад мэдээлэл рүү иргэн зөвшөөрөлгүйгээр, иргэн зөвшөөрөөгүй үед мэдээллийг дамжуулах боломжгүй. Энэ бол нууц нууцын мэдээлэлдээ орно. Харин саяын царай таних гэдэг бол яг царайг нь нэг удаа таньчхаад энэ хүн ийм байна гэдгийг цагдаагийн байгууллага дээр нэг удаа бүртгэгдсэн мэдээлэл нь дахиж гарч ирвэл тэр камерын систем нь энэ дахиад гараад ирлээ энэ хүн байна гэдэг байдлаар таньж байгаа. Түүнээс хувь хүний мэдээллийг өгч болохгүй гэсэн тийм зарчимтай. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баатархүү сайдын микрофоныг нэмж өгье. Энэ тал нь асчихлаа.

Ц.Баатархүү: Баярлалаа. Ер нь энэ хот, аймаг, дүүргүүд энэ камерыг иргэдийн хурлынхаа төсөв дээр тавиад, камержуулалтын ажлыг хийдэг. Камерын стандарт гэдгийг олон байгууллагаас санал авч байгаад тэгээд л өөрийнхөө төсөвт тохируулаад ер нь баталчихдаг юм байна лээ. Тэгээд энийг нь хэн эвдэрч байгаа, хэдэн хувь нь эвдэрч байгаа, дахин төсөв дээр тавьж байгаа юм бэ гэдэг бол их том асуудал шүү. Тэгээд энэ эвдрэлийг нь мэдээлэл харилцаа холбооны компанийг

явуулаад бид орон нутгууд дээр байгаа эвдрэлүүдийг шалгаад үзэхэд эвдрэлийн дийлэнх хувь нь сүлжээний гэмтэл байдаг. Гэтэл аймаг орон нутаг маань сүлжээний гэмтэл гарчхаад байхад түүнийг камер эвдэрсэн байна гээд дахиад камер дээрээ төсөв тавьж байдаг. Энэ бол төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулж байгаагийн нэг жишээ гэж бид үзэж байгаа. Тийм учраас аймаг орон нутаг руу энэ камерын арчлалтыг мэргэжлийн байнга 21 аймаг, бүх сумд сүлжээ хариуцаж байна.../минут дуусав/

Ж.Золжаргал: Микрофон нэмж өгье.

Ц.Баатархүү: Мэдээлэл харилцаа холбооны компаниар арчлалтаа хийлгээч гэдэг саналуудыг өгдөг. Мэдээж арчлалт хийж байгаа учраас тодорхой хэмжээний зардал гардаг. Гэхдээ тэдэн хувь нь эвдэрсэн байна, нэмээд дахиад орон нутгийн төсөв дээр тавья гэснээс хямдхан ийм зардлыг өгдөг. Энэ дээр бас гишүүд дэмжиж өгөөрэй. Ер нь ингээд дүүргийн төсөв камер шийддэг, нийслэл камер шийддэг хэд нь ажиллаж байгаа юм, ямар ч бүртгэлгүй нэг ийм зүйл яваад байдаг. Тэгээд яг манай яам энд оролцох гэхээр манай чиг үүрэг биш гэж үздэг. Та нар бол энэ камерынхаа л энэ дата өгөгдөл дээр зөвлөгөө өг, камерын стандарт дээр өг энэ бол ингээд тухайн орон нутгийн эрх мэдлийн өөрийн асуудлаа гэж үзээд байдаг. Гэтэл бид энэ дээр камерын хэдэн хувь нь жилдээ унтарч байна, эвдэрч байна вэ гэдэг дээр судалгаа хийчихсэн байгаа. Хүсвэл танд энэ судалгааг өгье гэж бодож байна. Та маш зөв асуудлыг хөндлөө. 2 дугаарт нь 4 сарын 4 буюу өнөөдөр 2-ны өдөр. 4-ний өдөр зөвлөл Виртуал бүсийн зөвлөл хуралдаж.../минут дуусав/

Ж.Золжаргал: Микрофон нэмж өгье.

Ц.Баатархүү: 4-ний өдөр, тэгээд 4-ний өдөр буюу нөгөөдөр бид хуралдана. Тэгээд хуулийн нэмэлт, өөрчлөлт, аль журмаа батлах юм, аль журам батлаад ч бас хангалттай үйлчлэх хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэхгүй юм бэ гэдгээ шийдээд явна. Энэ Виртуал бүсийн зөвлөлд зөвхөн ингээд манай яам бас байдаггүй. Нөгөө оролцогч талууд гэхээр Хууль зүйн яам, Сангийн яам, татвар, нийгмийн даатгал, манай энэ холбоо, хувийн хэвшил гээд маш олон төлөөллүүдтэй 2 том ажлын хэсэг явж байгаа гэдгийг танд онцолъё. Баярлалаа.

Ж.Золжаргал: Хугацааны хувьд асуусан шүү дээ, нөгөө 26 оны төсөв ярихаасаа өмнө юмаа цэгцэлчхээд ороод ирэхээр, 4 сардаа багтчихна гэж үзэж байгаа юм байна тийм ээ? Баярлалаа. Их чухал сэдвээр ярилцлаа гэж бодож байна. Өнөөдөр сонссон нь их зөв боллоо гэж бодож байна. Тэгээд 2 асуудал дээр бид энэ салбар дээр чинь ингээд хүмүүст маш их хүлээлт байгаад байна шүү дээ нөгөө IT хөгжүүлэгч нарт. Тэгэхээр бодит байдлыг, хугацаатай нь хэлэх хэрэгтэй байна. 1 дүгээрт нь энэ их өгөгдлийг аваад ашиглаад AI хөгжүүлэх, бизнестээ хэрэглэх хугацаа маань эхний файлууд нь 6 дугаар сард гарч ирэх юм байна. Өнөө маргааш бол байхгүй байна. 2025 оны 6 дугаар сараас эхлээд ингээд алхам алхмаар оруулах зорилтыг салбарын яам маань тавьчхаад явж байна гэж нэг энэ.

2 дугаарт нь IT-чдийг дэмжих нөгөө гол хууль маань энэ 25 онд олигтой хөнгөлөлтийг авч чадахгүй юм байна. Төсөвт тусаагүй, 26 оноос авч эхлэх нь байна. Яагаад гэхээр хуулийг дагаж гарах журмууд нь төвөгтэй, бусад хуулиуд дээр өөрчлөлт орох шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрчихсэн, 4 дүгээр сард багтаад эцсийн шийдлүүд гарч ирэх нь байна. Тэгэхээр энэ Виртуал бүсийн зөвлөлийн чинь дарга нь Ерөнхий сайд байгаа. Тэгээд бусад яамдаас орсон ийм том зөвлөл. Тэгэхээр энэ зөвлөл дээрээ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

шаардлагаа нэлээн хүчтэй тавиасай. Дараа жилийн төсөв ярихаас өмнө асуудлаа бид эрх зүйн орчноо бүрдүүлэхгүй бол дахиад 27 он болох магадлалтай. Тэгээд ерөнхий нэг ийм хандлага нь болохоор цахим хөгжил инновац, яах вэ нэг ийм ингэсхийгээд явж л байг энэ их гоё юм. Гоё хууль баталчихсан, тэгэхдээ тэр нь хэрэгждэггүй, төсөв байдаггүй. Төсөв нь болохоор инновац технологи дээр дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувьд хүргэнэ, Баялгийн сангийн 1 хувь байна энэ тэр гээд. Тэгээд чуулган дээр бид яг ингээд хэлэлцээд асуухаар зэрэг тийм, тийм юм байгаа, тэгж байгаад бид хугацаа бас байгаа юм чинь гэсэн иймэрхүү хандлагатай байдаг.

Тэгэхээр бид нэг ийм хэрэгждэггүй хууль баталчхаад, тэгээд нийгэмдээ нэг баахан хүлээлт үүсгээд, тэгээд нөгөөдүүл маань ингээд Казахстанд, Узбекистанд ийм гоё яваад байна шүү дээ гэхээр зэрэг удахгүй бид байх гэж байгаа гээд хүлээлт үүсээд ингээд байгаад байдаг. Компаниуд нь хүнд нөхцөлтэй байгаад байдаг. Тийм болохоор салбарын яам нь санаачилгатай ажиллаж байгаа. Тэгэхдээ илүү их хурдтай шахаж шаардаад, Байнгын хорооны зүгээс ямар дэмжлэг хэрэгтэй юм, бусад яамтай яаж ажиллах юм, тогтоол гаргах хэрэгтэй бол тэр төсөл дээр нь хүртэл хамтарч ажиллаад явъя гэсэн ийм дүгнэлтийг хэлээд, өнөөдрийн хурлаа дуусгая. Тэгээд салбарын сайд Баатархүү болон ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Салбарын төлөөлөлд баярлалаа.

18.32 цаг

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хурал хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА